

Ерөнхий боловсролын сургуулиудаас ирүүлсэн “Эрчим хүчний хэмнэлт, зохистой хэрэглээ хичээлийн тайлан



<p>Оршил</p> <p>Алтангарал</p> <p>би эрчим хүчээ хэмнэж зөв зохистой хэрэглэхэд нэгдэж байна.</p> <p>Гарын үсэг: <i>[Signature]</i></p> <p>2019 оны 11 сарын 23 өдөр</p>	<p>Ариундалсан</p> <p>Мунхуйт</p> <p>би эрчим хүчээ хэмнэж зөв зохистой хэрэглэхэд нэгдэж байна.</p> <p>Гарын үсэг: <i>[Signature]</i></p> <p>2019 оны ...сарын ...өдөр</p>	<p>Энэ тугийн</p> <p>Анх үсэг</p> <p>би эрчим хүчээ хэмнэж зөв зохистой хэрэглэхэд нэгдэж байна.</p> <p>Гарын үсэг: <i>[Signature]</i></p> <p>2019 оны 11 сарын 22 өдөр</p>
--	---	---




Эрчим хүчний хэмнэлт, зохистой хэрэглээ хичээлийн тайлан

Нийслэлийн 19-р сургууль


Хичээлийг өгөгдсөн хөтөлбөрийн дагуу 3-р улиралд зохион байгуулж явууллаа.
Хичээлийн үр дүнг дараах ажлуудаар тайлагналаа.

№	Анги	Хийгдэх ажил
1	1-р анги	“ Эрчим хүчийг зөв хэрэглэх, хэмнэх “ зураг зурах
2	2-р анги	“ Эрчим хүч зөв зохистой хэрэглэх, хэмнэх “ санамж бичиж байрлуулах
3	3-р анги	Бүтээл хийх
4	4-р анги	“ Эрчим хүчний хэрэглээ, хэмнэлт “ зохион бичлэг
5	5-р анги	“ Эрчим хүчний хэрэглээ хэмнэлт “ сэдвээр илтгэл тавих



Эрчим хүчний хэмнэлт, зохистой хэрэглээ хичээлийн тайлан


Нийслэлийн 19-р сургууль



3-р анги - Бүтээл хийх

Эрчим хүчний хэмнэлт, зохистой хэрэглээ хичээлийн тайлан

Нийслэлийн 19-р сургууль



4-р анги – “Эрчим хүчний хэрэглээ, хэмнэлт” зохион бичлэг

5-р анги – “Эрчим хүчний хэрэглээ, хэмнэлт” сэдвээр илтгэл танилцуулах



Эрчим хүчний хэмнэлт, зохистой хэрэглээ хичээлийн тайлан

Нийслэлийн 24-р сургууль

БАЗАН-ийн “Эрчим хүч-Зохистой хэрэглээ” сайн хичээлийн үйл ажиллагааны тайлан

“Эрчим хүч-Зохистой хэрэглээ”-ний тухай хичээл 1-5-р ангиудад 3-р улиралд заагдаад дуусч байна. Сурагчдад эрчим хүч гэж юу вэ, түүнийг хэмнэх, ашиглах талаар мэдлэг олгож, амьдралд хэрэгтэй, хэрэгжүүлэхэд хялбар дөхөм арга, зөвлөмжүүдийг өгч, хэмнэх, тооцоолох, зохион байгуулах чадварыг хичээл, танхим, туршилтын аргаар сургадаг сайн талтай хичээл юм. 2019-03-18-19-ний өдрүүдэд БАЗАН-ийн секц бүрээс анги бүрийн агуулгад тохирсон үзүүлэх хичээлүүд зааж, сайн хичээлийн сангаа баяжуулан, багш нар арга туршлагаа солилцсон үйл ажиллагааг зохион байгууллаа.

ЗАС	Багшийн нэр	Заах цаг	Анги	Кабинет №	Сэдэв
1-р анги	Х.Батдэлгэр	10-10.35	1Ё	212	Эрчим хүч гэж юу вэ?
2-р анги	Б.Энхсүвд	11-11.35	2Д	105	Эрчим хүчийг хэмнэх нь
3-р анги	Л.Цэгмэд	15.00-15.40	3Б	207	Эрчим хүчний хэрэглээ ба хэмнэлт
4-р анги	С.Должин	15.50-16.30	4А	212	Эрчим хүчийг хэмнэх аргууд
5-р анги	Н.Солонго	14.00-14.40	5Б	304	Эрчим хүчний зохистой хэрэглээ ба хэмнэлт



“Эрчим хүч-Зохистой хэрэглээ” хичээлийг сурагчид маш их сонирхож, хүүхэд бүр өөрөө туршиж үзэх болон хийж бүтээж оролцох хүсэлтэй байгаа нь багш бүрийн хичээл дээр илт ажиглагдаж байлаа. Мөн багш нар маань сурагчдынхаа нас, сэтгэхүйн онцлогт тохируулан хичээлүүдээ сайтар бэлдэж, үзүүлэх бодит жишээ, гарын авлагууд, хялбар дөхөм болгосон үйл ажиллагааны алхмууд, ажлын хуудсуудыг бэлтгэж сурагчдаар мэдлэг бүтээлгэх үйл ажиллагааг чадварлаг удирдан зохион байгууллаа.

Хичээлийн хэлэлцүүлгийг арга зүй, туршлага, ур чадвараа хуваалцан, нэг нэгнээсээ суралцах хэлбэрээр зохион байгууллаа. Сургалтын менежер С.Сарантуяа болон ахмад багш Н.Мөнхтуяа, С.Нарантуяа, Ж.Буянхишиг, багш Д.Эрдэнэтуул, Д.Мөнхзаяа, Д.Эрдэнэтуяа, Д.Чанцалдулам зэрэг багш нарын хичээлийг үр дүнтэй, өгөөжтэй зохион байгуулах арга зүйн зөвлөмж, багшлах ур чадварын талаарх зөвлөгөө, ярилцлага залуу багш нар төдийгүй нийт багш нарт хийх бүтээх урам өгсөн үйл явдал боллоо. Мөн хийсэн хэрэглэгдэхүүн, гарын авлагыг хэрхэн хөрвүүлж ашиглах талаар санал солилцож, дараагийн хийх бүтээлч ажил болон сургалтынхаа товыг тодорхойлцгоолоо.

Эрчим хүчний хэмнэлт, зохистой хэрэглээ хичээлийн тайлан

Үнэлгээний үзүүлэлт:

Хичээлийн бэлтгэл

- ✦ Сэдэлжүүлэлт ба багшийн оновчтой асуултууд
- ✦ Хэрэглэгдэхүүний оновчтой байдал, ашиглалт
- ✦ Самбар төлөвлөлт
- ✦ Багшийн анги дүүрэн хараа, сурагчдыг хамран оролцуулж буй байдал
- ✦ Хичээлийн төлөвлөлт, зорилгоо хангасан эсэх
- ✦ Үйл ажиллагаануудын залгамж холбоо, хичээлүүдийн интеграци
- ✦ Оновчтой жишээ, туршилт хийсэн эсэх гэсэн үндсэн 8 шалгуураар хичээлүүдээ оноожуулан дүгнэлээ.

Нийслэлийн 24-р сургууль



Эрчим хүчний хэмнэлт, зохистой хэрэглээ хичээлийн тайлан

Нийслэлийн 32-р сургууль

Эрчим хүчний хичээлийг хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу 14 хоногт 1 удаа хичээллэсэн. Ээлжит хичээл бүрээр багш бүр сургалтын хэрэглэгдэхүүн, цахим хичээл, видео хичээлүүдийг бэлтгэж зааж байлаа.

Эрчим хүч хичээлийн хүрээнд дараах үйл ажиллагааг зохион байгууллаа.


1. Эрчим хүч - зохистой хэрэглээ гар зургийн үзэсгэлэн анги бүр гаргасан
2. “Эрчим хүчээ хэмнэцгээе” аян



“Эрчим хүчээ хэмнэцгээе” аяны хүрээнд:

- ✓ Өдөр тутамдаа эрчим хүчний хэрэглээний талаар зөв дадал хэвшилтэй болгох зорилгоор анги бүрт эрчим хүчээ хэмнэх 20

Зорилгын биелэлтийг хангах зорилгоор “Эрчим хүчний хэмнэлттэй хамт олон” шалгаруулах уралдааныг зохион байгуулсан.



Цахим хичээл



Эрчим хүчний хэмнэлт, зохистой хэрэглээ хичээлийн тайлан

Нийслэлийн 32-р сургууль

Сурагчдын дэвтрийн үйл ажиллагаа:



Хичээлийн үйл явцаас:



Тайлан бичсэн багш: Б.Мөнхтуяа

Эрчим хүчний хэмнэлт, зохистой хэрэглээ хичээлийн тайлан

Нийслэлийн 37-р сургууль



БАЗАНэгдэл 27 багш-Судлах цаг, хөтөлбөр төлөвлөгөөгөө боловсруулж туршлага арга зүйгээ солилцлоо.



“Эрчим хүчний хэмнэлт-Зохистой хэрэглээ” сургалтыг ХГҮА-ны цагаар сурагчдын насны онцлогт тохирсон арга зүйгээр сурагчдад олголоо.



Сурагчдын дунд “АХА” тэмцээнийг зохион байгуулсан.



Сайн хичээлийн туршлага солилцлоо.



Сурагчдын орчин мэдээллийг хангах, идэвхжүүлэх аргуудыг хэрэгжүүлэн явууллаа.



Эрчим хүчний хэмнэлт, зохистой хэрэглээ хичээлийн тайлан

Нийслэлийн 47-р сургууль

1 ангийн “Эрчим хүч-зохистой хэрэглээ” хичээлийн тайлан

Энэ 3-р улиралд 1 ангийн сурагчид маань “Эрчим хүч-зохистой хэрэглээ” сэдвийн дор 9 цагийн нэгж хичээлийг хөтөлбөрийн дагуу судлан суралцав.

Энэ хичээл нь сурагч болон багшид эрчим хүчний тухай мэдлэг өгсөн их үр дүнтэй хичээл байлаа. Сүүлийн цагийн хичээл дээр багштайгаа хамтран дүгнэлт сорилыг ажиллав.

2 ангийн “Эрчим хүч-зохистой хэрэглээ” хичээлийн тайлан

Сурагчид цахилгаан дулаан ямар их хөдөлмөрөөр, олон хүний зүтгэлээр дулаан ,гэрэл ирж байгаа дамжлагийг харж ярилцаж байгаа нь:

Сурагчид цахилгааны аюулгүй байдлын талаар мэдээлэлтэй болж мэдсэн зүйлээрээ хэлэлцүүлэг хийв.

Сурагчид баг болон хуваагдаж цахилгаан эрчим хүчний тухай мэдээлэл цуглуулж ярилцав.



Дүгнэлт хичээл:

9 цагийн хичээл үр дүнтэй байж, эцэг эхчүүддээ сургалт өгөн, хэлэлцүүлэг хийн, мэдээлэл цуглуулан хаанаас яаж эрчим хүч бий болдог талаар, хэрхэн хэрэглээгээ зөв зохистой болгох талаар багагүй мэдлэгтэй болж, чадвар суусан хэмээн үзэж байна.

Эрчим хүчний хэмнэлт, зохистой хэрэглээ хичээлийн тайлан

Нийслэлийн 47-р сургууль

3 ангийн “Эрчим хүч-зохистой хэрэглээ” хичээлийн тайлан

Тухайн хичээлүүдээр хэрхэн юу ойлгосноо сурагчид зургаар илэрхийлэн үзүүлээ.



Баг болон хамтарч эрчих хүч зохистой хэрэглээ гэсэн хичээлээрээ ханын сонин хийж, илтгэл тавив.

4-р ангийн “Эрчим хүч” хичээлийн тайлан:

Дүгнэлт:

Эрчим хүч “ хичээл орсноор сурагчид цахилгаан эрчим хүчний талаар тодорхой мэдлэгтэй болж, түүнийг амьдрал практикт \ангидаа,гэртээ\ хэрэглээ болгох, эрчим хүчний ач тусыг мэдрэх танин мэдэхүйн ач холбогдолтой юм. Энэ нь бүлэг сэдвийн сорил даалгавраас харахад мэдэгдэж байлаа.



5-Р АНГИЙН “ЭРЧИМ ХҮЧ” ХИЧЭЭЛ

Амьдрах чадварт суралцах үйл ажиллагаа хичээлээр III улиралд “Эрчим хүч” сэдвээр нийт 9-н цагийн ээлжит хичээлийг бэлтгэн заасан.

7 хоног гэрийн бүх гишүүдийн оролцоотой эрчим хүчээ хэмнэх дүрэм гаргаж цаасан дээр хүснэгтлэн тэмдэглэл хийсэн байгаа



ТАЙЛАН ХИЙСЭН: П.ОТГОНТУЯА

Эрчим хүчний хэмнэлт, зохистой хэрэглээ хичээлийн тайлан

Нийслэлийн 10-р сургууль

Нийслэлийн Ерөнхий Боловсролын 10дугаар сургууль 2018-2019 оны хичээлийн жилд 1-5р ангийн 15 бүлэгт Эрчим хүчний зохистой хэрэглээ сургалтыг явууллаа.

Хийгдсэн үйл ажиллагаа:

- 2018 оны 10-р сард бага ангийн 14 багшид сургуулийн сургагч багш О.Энхсайхан “Эрчим хүчний зохистой хэрэглээ” сэдэвт 3 цагийн сургалт
- “Арга туршлага солилцох цаг” үйл ажиллагааны үеэр өмнө жилүүдэд гарч байсан хүндрэл бэрхшээл, ололттой талуудаа хэлэлцсэн.
- Тус сургалтын үеэр багш нар өмнөх хичээлийн жилд боловсруулсан сургалтын хөтөлбөр, нэгж хичээлийн хөтөлбөр, хэрэглэгдэхүүн материалаа дараа дараагийн ангийн багш нартаа шилжүүлж, арга зүйн талаар санал солилцсон.
- Дулааны цахилгаан станцын талаарх мэдээллийг сургалтын менежер Б.Пүрэвдорж танилцуулсан.
- Эрчим хүчний зохистой хэрэглээг сурталчлах зурагт хуудсыг анги танхим, сургуулийн орчинд байршуулсан.
- Багш Д.Түвшинжаргал “Индүүний хэрэглээ ба хэмнэлт”, багш Д.Усника “Эрчим хүчээ хэмнэе” сэдвээр хичээл зааж туршлагаа хуваалцлаа.



Тайлан бичсэн: Сургалтын менежер Б.Пүрэвдорж

Эрчим хүчний хэмнэлт, зохистой хэрэглээ хичээлийн тайлан

Нийслэлийн 13-р сургууль

СУРГАЛТЫН МЕНЕЖЕР **БАТЛАВ Г.НАЛЖИРМАА**

ХИЧЭЭЛЭЭС ГАДУУРХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨР

2018-2019 оны хичээлийн жил 5-р анги

Сэдэв	Ерөнхий чадвар	Цаг	Сар өдөр	Ээлжит хичээл
I УЛИРАЛ Гар утасны хэрэглээ 8 цаг	Гар утасны зүй зохистой хэрэглээнд суралцах	1	1x/7	Харилцаа холбооны үүсэл, хөгжил
		1	14	Харилцаа холбооны тоног төхөөрөмжийг зөв ашиглах
		1	21	Гар утас хэрхэн үүссэн бэ?
		1	28	Гар утасны хэрэгцээ, шаардлага
		1	8/5	Утас түүний аюулгүй ажиллагаа
		1	12	Гар утасны зохистой хэрэглээ, соёл
		1	19	Гар утасны хор уршиг, сөрөг нөлөө
		1	26	Дадлага хичээл
II УЛИРАЛ Замын хөдөлгөөн 7 цаг	Замын хөдөлгөөнд хэрхэн аюулгүй оролцох ойлголттой болох	1	8/9	Тээврийн хэрэгслийн үүсэл, хөгжил
		1	16	Замын хөдөлгөөний дүрэм гарсан түүх
		1	23	Замын цагдаагийн газар, зохицуулагч гэж хэн бэ?
		1	30	Гэрлэн дохио
		1	4/7	Гудамж, замыг аюулгүй нэвтрэх журам
		1	14	Замын тэмдэг, гудамж замын хөдөлгөөн
III УЛИРАЛ Эрчим хүч - Зохистой хэрэглээ 9 цаг	Эрчим хүчийг хэмнэж сурах, зүй зохистой хэрэглэх	1	4/15	Эрчим хүчний үүсэл, гарал
		1	22	Цахилгаан эрчим хүчний эх үүсвэр
		2	4/18	Эрчим хүчний үйлдвэрлэл
		1	25	Эрчим хүчний дамжуулалт
		2	22	Эрчим хүчний хэмнэлт, үр ашиг
		1	29	Эрчим хүчний үр ашиг тэдгээрийг ач холбогдол
IV УЛИРАЛ Ардын хөлөгт тоглоом 9 цаг	Ардын уламжлалт тоглоомоо тоглож сурах Ёс заншлаасаа суралцах	1		Эвт шаазгай
		1		Тэгнээ
		1		Шорлох
		1		Чихэн чагнаа
		1		Өндөр хангайн буга
		1		Дөрвөн буга
		1		Холбоо буга
		1		Ижил буга
1		Соёондой		

БОЛОВСРУУЛСАН: 5-Р АНГИЙН ЗАН

СУРГАЛТЫН МЕНЕЖЕР **БАТЛАВ Г.НАЛЖИРМАА**

ХИЧЭЭЛЭЭС ГАДУУРХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НЭГЖ ХӨТӨЛБӨР

- Нэгж хичээлийн сэдэв:** Хэрэглээ ба хэмнэлт
- Судлах цаг:** 8 цаг
- Зорилго:** Эрчим хүчний зохистой зөв хэрэглээ, хэмнэх аргын тухай ойлголттой болох
- Зорилт:**
 - ❖ Цахилгаан хэрэгслийг зөв ашиглаж хэрэглэх
 - ❖ Цахилгаан хэрэгслийн аюулгүй ажиллагааг дагаж мөрдөх
 - ❖ Цахилгаан эрчим хүчээ хэмнэх
 - ❖ Цахилгаан хэрэгслийн шошго тэмдэглэгээг унших
- Агуулга:**

Судлагдахуун	Ур ухаан
<ul style="list-style-type: none"> ➢ Хэрэглээ ➢ Хэмнэх аргууд 	<ol style="list-style-type: none"> Гэрэл, хөргөгч, зурагт, ус буцалгагч зэргийг зөв хэрэглэж эрчим хүчийг хэмнэх аргуудыг тайлбарлах Тэмдэглэгээ \шошго\ уншиж тайлбарлах Аюулгүй ажиллагааны дүрмийг тайлбарлах
- Хэрэглэгдэхүүн:** Зурагт хуудас, бичлэг, тараах материал
- Үнэлгээ:** Ярилцлага, ажиглалт, асуулт хариулт, ажлын хуудас
- Нэгж хичээлийн цагийн төлөвлөлт:**

№	Ээлжит хичээлийн сэдэв	хугацаа	Сар өдөр	Эзэмших чадвар
1	Гэрэл түүний хэрэглээ	40 мин	15/17	1.Цахилгаан хэрэгслийг зөв хэрэглэх
2	Хөргөгчтэй зөв харьцах	40 мин	24	
3	Ус буцалгагч ашиглах	40 мин	2/1	2. Хэрэглэхдээ хэрхэн хэмнэлт гаргах болох тухай
4	Зурагтын хэрэглээ	40 мин	8	
5	Цахилгаан эрчим хүчний аюулгүй ажиллагаа	40 мин	15	3. Аюулгүй ажиллагааны дүрмийг баримтлах
6	Эрчим хүч хэмнэх аргууд	40 мин	26	
7	Байгалийн гэрэл ашиглах нь	40 мин	29	
8	Сорил тест	40 мин	2/с.	

Эрчим хүчний хэмнэлт, зохистой хэрэглээ хичээлийн тайлан

Нийслэлийн 62-р сургууль

2018-2019 оны хичээлийн жилд эрчим хүчний сургалтыг бага ангийн 63 багш, 2700 гаруй сурагчдын дунд зохион байгууллаа. 2018 оны 10 сарын 16 нд сургалтын менежерүүд эрчим хүчний сургалтанд хамрагдан, сургалтаар Дулааны III цахилгаан станц болон сэргээгдэх эрчим хүчний дэд станцын үйл ажиллагаатай танилцан “Эрчим хүчийг ашигтай хэмнэхийн ач холбогдол” сургалтанд сууж өөрийн сургууль дээрээ багш нартаа сургалтыг зохион байгууллаа. Мөн анги удирдсан багш нар II, III улирлын хичээлээс гадуурх үйл ажиллагааны цаг дээр эрчим хүчний сургалтыг зохион байгуулж сурагчдад эрчим хүч хэрхэн үүссэн, эрчим хүчийг хэмнэх, хамгийн их, хамгийн бага эрчим хүч хэрэглэдэг цахилгаан хэрэгслэл зэргийн тухай ойлголтыг өглөө. Мөн анги удирдсан багш нар ангийн эцэг эхчүүддээ эрчим хүчний сургалтыг зохион байгуулав. Эрчим хүчний сургалтаар сурсан мэдсэнээрээ сурагчид гарын авлага, гэрийнхэндээ зориулсан зөвлөмж, зурагт хуудас, бяцхан ном, гар зургийн уралдаан, аха тэмцээн зэргийг зохион байгууллаа



АХА тэмцээний үеэр



АХА тэмцээнд оролцсон сурагчид



Багш нарын сургалтын үеэр



Эрчим хүчний хэмнэлт, зохистой хэрэглээ хичээлийн тайлан

Нийслэлийн 71-р сургууль



Нийслэлийн хэмжээнд зохиогдсон “Эрчим хүчний хэрэглээ” сургалтад хамрагдлаа.



Бага ангийнхаа багш нарт сургалтаа явууллаа



Багш нар сургалтанд хамрагдсанаар сурагчид болон эцэг эхчүүдэд эрчим хүчний зохистой хэрэглээ, эрчим хүчийг хэрхэн хэмнэх талаар сургалт зохион байгуулж явууллаа.

Эрчим хүчний хичээлийг энэ хичээлийн жилд I-IV ангид 3-р улиралд тус бүр 8 цагаар, V ангид 2-р улиралд 7 цагаар сургалтыг зохион байгуулж явууллаа.

Сурагчид сургуулийнхаа уурын зуухны үйл ажиллагаатай танилцлаа.



Дүгнэлт:

Эрчим хүчний сургалт явагдсанаар сурагчид болон эцэг эхчүүд эрчим хүчээ хэмнэх талаар ойлголттой болж, сарын тогны хэрэглээгээ тооцдог болсон мөн өдрийн гэрлийн хэрэглээг багасгаж нарны болон байгалийн гэрлийг ашиглаж сурсан. Эрчим хүчний зардлыг бууруулснаар түүнээс гарсан үр ашгийг тооцож хэмнэлт хийж сурсан. Эрчим хүчний хэмнэлттэй төхөөрөмжүүдийг таньдаг болсон. Залгуурыг зөв залгаж салгах аюулгүй байдлыг мэддэг болсон. Үр ашиггүй зардал нь бидний амьдралд ямар хор хохирол үзүүлж байгаа талаар ойлголттой боллоо. Сургалтаас олж авсан мэдлэгээ бусдадаа дамжуулан эрчим хүчний зохистой хэрэглэх талаар мэдлэг чадвараа сайжрууллаа.

Эрчим хүчний хэмнэлт, зохистой хэрэглээ хичээлийн тайлан

Нийслэлийн 72-р сургууль

Эцэг эхийн нэг өдрөөр “Эрчим хүчний зөв хэрэглээ-Аюулгүй ажиллагаа” хичээлээр сургалт зохион явуулав.



2-р ангийн сурагчдын дунд “Эрчим хүч-Зохистой хэрэглээ” сэдвээр гар зургийн уралдаан зохион явуулав.



Эрчим хүчний зохицуулах хорооны эрчим хүчийг зөв хэрэглэх үзүүлэн тараах материалыг хүүхдийн үзэгдэх орчинд байршуулан тараасан.



5-р ангийн сурагчдаар “Эрчим хүчээ хэмнэдэг- миний арга” сэдвээр бяцхан ном хийлгэв.



5-р ангиудын дунд “Алтан хонх” зохион явуулав.



Эрчим хүчний хэмнэлт, зохистой хэрэглээ хичээлийн тайлан

Нийслэлийн 74-р сургууль

1-5 Дугаар ангийн 10 багш 10 ээлжит хичээл заалаа.
Хичээлд нийт 279-274 суралцагчид хамрагдлаа.

4б анги багш Б.Долгоржав “Аюулгүй ажиллагаа”
хичээлийг 28 - 28 суралцагчдад заалаа.



3а анги багш Г.Отгонбаяр “Салхин ба
усан тээрмийн ойлголттой болох”
хичээлийг 26 - 26 суралцагчдад заалаа.



16 анги багш М.Нямбат “Эрчим хүч үүссэн түүх”
сэдэвт хичээлийг 26-24 суралцагчдад заалаа.



2б анги багш Э.Хонгорзул “Эрчим хүчний
үйлдвэрлэл” сэдэвт хичээлийг 36-36 суралцагчдад
заалаа.



5а анги багш В.Дуламсүрэн “Эрчим хүчний
хэмнэлт ба үр ашиг” хичээлийг 32-31
суралцагчдад заалаа.



4а анги багш Ч.Алтанцом “Индууг
зөв зохистой хэрэглэх” хичээлийг
28 - 28 суралцагчдад заалаа



ТАЙЛАН БИЧСЭН

БАГА АНГИЙН БАГШ

В.ДУЛАМСҮРЭН

17

Эрчим хүчний хэмнэлт, зохистой хэрэглээ хичээлийн тайлан

Нийслэлийн 92-р сургууль

2018-2019 оны хичээлийн жилийн 3-р улиралд ХГҮА-ны цагаар заах аргын нэгдэл бүр “Эрчим хүч-зохистой хэрэглээ” хичээлийг сурагчдын насанд тохирсон байдлаар төлөвлөгөө боловсруулан, төлөвлөгөөнийхөө дагуу сургалтыг анги бүртээ амжилттай зохион байгуулснаар хүүхэд бүр эрчим хүчний хэмнэлт, зөв зохистой хэрэглэх талаарх мэдлэг мэдээлэлтэй болсон.

❖ 1-р ангийн ЗАН-ийн Эрчим хүч-зохистой хэрэглээ сургалтаар хэрэгжүүлсэн үйл ажиллагаа

Дүгнэлт: Тус хичээлийг орсноор амьдралд ойр бодит зүйлтэй харьцахад хялбар болох аюулгүй ажиллагааны дүрмийг баримтлах талаар алхам алхмаар эрчим хүчний ойлголттой болсон. Сурагчид зарим зүйлс аюултай байдаг талаар мэдлэгтэй болсон. Эцэг эхчүүд тус хичээл нь амьдралд тустай үр дүнтэй байсан талаар хэлж байсан.



❖ 3-р ангийн ЗАН-ийн Эрчим хүч-зохистой хэрэглээ сургалтаар хэрэгжүүлсэн үйл ажиллагаа

2-р сарын 11 –нээс 4-р сарын 5-ныг хүртэл хичээлийн 3-р улиралд хичээлээс гадуурх ажлаар 3-р ангиудад эрчим хүчний хичээлийг үзэж судаллаа.

Хичээл дээр ЭХЗГ-аас гаргасан эрчим хүчийг хэмнэх тухай цуврал видео киног үзэж хүүхэд бүр эрчим хүчээ хэмнэх тухай зөвлөмж бичсэн ба зургийн уралдаан зарлаж дүгнэсэн. Энэ хичээл нь сурагчдад багаас нь эрчим хүчээ хэмнэх, зөв дадал хэвшилтэй болоход нь тусалсан үр дүнтэй хичээл боллоо.

❖ 2-р ангийн ЗАН-ийн Эрчим хүч-зохистой хэрэглээ сургалтаар хэрэгжүүлсэн үйл ажиллагаа

Эрчим хүчний хичээлээр нийт 8 цагийн хичээл судаллаа. 3-р улиралд 2-р ангийн зургаан бүлгийн 210 хүүхдэд хичээл заасан.

Энэхүү хичээл орсны үр дүнд сурагчид гэр болон ангийн тогоо хэмнэж өдрийн цагаар эрчим хүчээ хэмнэн гэрлээ асаах нь багассан. Мөн болзошгүй аюул бүхий залгуур, цэнэглэгч гэх мэтчилэн хэрэглээний зүйлсээс өөрсдийгөө хамгаалж сурсан.



Эрчим хүчний хэмнэлт, зохистой хэрэглээ хичээлийн тайлан

Нийслэлийн 92-р сургууль


❖ 4-р ангийн ЗАН-ийн Эрчим хүч-зохистой хэрэглээ сургалтаар хэрэгжүүлсэн үйл ажиллагаа

IY ангийн нийт 7-н бүлгийн 255 сурагч энэ хичээлд амжилттай хамрагдлаа.

Хүн бүр өөрийн цахилгаанаа хэмнэж зөв зохистой хэрэглэж хэвшсэн үр дүнтэй хичээлүүдийг үзэж дүгнэлээ.

Хүүхэд бүрт дараах гарын авлагыг хувилж өгч, гэр бүлдээ тайлбарлан таниулах ажлыг хийлээ.

Сурагчид ээж аавтайгаа хамтран эрчим хүчний хэрэглээ сэдвээр бяцхан ном хийлээ.



❖ 5-р ангийн ЗАН-ийн Эрчим хүч-зохистой хэрэглээ сургалтаар хэрэгжүүлсэн үйл ажиллагаа

5-р ангийн 212 суралцагчдад “ЭРЧИМ ХҮЧ-ЗОХИСТОЙ ХЭРЭГЛЭЭ” хичээлийн агуулгыг 3-р улирлын ХГҮА-ны цагаар төлөвлөгөөний дагуу орж мэдлэг чадвар эзэмшүүллээ.

Дүгнэлт: Хүүхдүүд эрчим хүчний эх үүсвэрийг мэдэх, эрчим хүчээ ахуйн хэрэглээндээ зөв зохистой хэрэглэх, цахилгаан хэрэгслийн тэмдэг, тэмдэглэгээг мэдэх, гэрлийн шилийг зөв сонгох, тооцоог нарийвчлан гаргах, бусдад зориулан уриалга гаргах зэрэг олон зүйлийг мэдсэн үр дүнтэй хичээл байлаа.



Эрчим хүчний хэмнэлт, зохистой хэрэглээ хичээлийн тайлан

Нийслэлийн 103-р сургууль

Тус сургуулийн 1-5 дугаар ангийн 13 бүлэгт суралцаж буй 337 суралцагчдад 2018-2019 оны хичээлийн жилийн 3-р улиралд Хичээлээс гадуурх үйл ажиллагааны цагаар “ Эрчим хүчний зохистой хэрэглээ” сэдвээр 8 цагийн сургалтыг сурагчдын нас сэтгэхүйд тохируулан хуваарийн дагуу агуулгыг багтаан “Цахилгааны зөв зохистой хэрэглээ, цахилгаан хэмнэлт, эрчим хүчийг хаанаас гарган авдаг вэ? Гэр бүлийн хэрэгцээнд цахилгаанаа хэрхэн хэмнэх тухай эцэг эхчүүд болон сурагчдад зурагт хуудас болон судалгаа, цахим хичээлээр дамжуулан орж сургалтыг хөтөлбөрийн дагуу зохион байгуулсан.

Сургалтын явцад сурагчид дараах үйл ажиллагаануудыг зохион байгууллаа. Үүнд ямар тохиолдлуудад цахилгааны мөнгө их гарах талаар мэдэж аван эцэг эхчүүддээ зурагт хуудсаар дамжуулан цахилгаанаа хэмнэх талаар ярьж өглөө. **Болохгүй шүү уриалга** гаргасан.



Сурагчид 5 дугаар хорооны ард иргэдэд сурталчилгаа болгон орцны хаалган дээр зурагт хуудас, сануулга 50ш нааж байршуулан нөлөөллийн арга хэмжээг зохион байгууллаа.

Анги бүр эцэг эхийн сурган хичээлээр “**ЭРЧИМ ХҮЧНИЙ ЗОХИСТОЙ ХЭРЭГЛЭЭ**” сэдвээр 1 удаагийн сургалт зохион байгуулах зэрэг үйл ажиллагаануудыг зохион байгуулсан.

Мөн сургалтын явцад сурагчдаас ахуйн судалгаа авлаа.

1. Хөргөгчний судалгаа: Тог бага иддэг хөргөгчтэй айл 76 байлаа. Ихэнх нь таних тэмдэггүй, хөргөгч хэрэглэдэг юм байна. 20% сөрөг
2. Утасны цэнэглэгчээ салгаж байна уу? гэсэн ажиглалтын судалгааг гэртээ хийгээд ирэх даалгаварт 113 хүүхдийн гэр бүлийн орчинд цэнэглэгч залгаатай орхидгийг мэдсэн. 43,3% сөрөг
3. Гэрээс гарахдаа, гэрт хэн ч байхгүй тохиолдолд зурагтын залгуурыг сууриар нь унтраадаг эсэх гэсэн асуулгад 84 нь зурагтаа удирдлагаар нь унтраадаг гэсэн байна. 80% сөрөг
4. Ямар гэрлийн чийдэн хэрэглэдэг вэ? гэсэн асуулгад Улайсдаг чийдэн 32 айл байна. 10% сөрөг

ТАЙЛАН БИЧСЭН:
СУРГАЛТЫН МЕНЕЖЕР О.ОЮУН


Эрчим хүчний хэмнэлт, зохистой хэрэглээ хичээлийн тайлан

Нийслэлийн 109-р сургууль

Энэ хичээлийг "Хүн орчин" болон Хичээлээс гадуурх үйл ажиллагааны цагаар 3-р улиралд 7 хоногт 1 цагаар орохоор төлөвлөн хуваарийн дагуу 96 цагийн хичээл заагдсан.



"Эрчим хүч-зохистой хэрэглээ" хөтөлбөрийг сургууль дээрээ хэрэгжүүлэх, сурагчдад заах талаар багш нартаа дэмжлэг үзүүлэн заах арга зүйн сургалтыг 10-р сард багш нартаа явуулж ХГҮА-ны цагийн төлөвлөлтөнд аль улиралд хэдэн цагаар заахыг тусгасан.

ЗАН-ээр ярилцан нэгдсэн хөтөлбөр гаргахаас гадна хичээлд хэрэглэгдэх материал, зурагт үзүүлэнг эх сурвалжуудаас татан бэлтгэх, ажлын хуудас боловсруулах ажлыг зохион байгуулж сургалт явуулах нөхцлийг хангасан.



Сурвалж	Тайлбар	Э. хэмн.	З. хэрэгл.	И. хэмн.	У. хэмн.
1. Гэр	Дэлгэрэнгүй тусгай материал	Хүч	Хүч	Хүч	Хүч
2. Гэр	Хүч	Хүч	Хүч	Хүч	Хүч
3. Гэр	Хүч	Хүч	Хүч	Хүч	Хүч

Сурвалж	Тайлбар	Э. хэмн.	З. хэрэгл.	И. хэмн.	У. хэмн.
1. Гэр	Дэлгэрэнгүй тусгай материал	Хүч	Хүч	Хүч	Хүч
2. Гэр	Хүч	Хүч	Хүч	Хүч	Хүч
3. Гэр	Хүч	Хүч	Хүч	Хүч	Хүч



Багш нар заах хичээлийнхээ төлөвлөлтийг бичиж боловсруулан сургалтын менежерээр баталгаажуулан сургалтаа явуулсан.

Анги танхим, сургуулийн коридорт эрчим хүчээ хэмнэх, залгуураа салгах санамжуудыг наахаас гадна сурагчдад цахилгаан хэрэгсэлтэй зүй зохистой харьцах заавар зөвлөгөөнүүдийг өгч аюулгүй байдлыг ханган ажиллаж хэвшлээ.



Сурвалж	Тайлбар	Э. хэмн.	З. хэрэгл.	И. хэмн.	У. хэмн.
1. Гэр	Дэлгэрэнгүй тусгай материал	Хүч	Хүч	Хүч	Хүч
2. Гэр	Хүч	Хүч	Хүч	Хүч	Хүч
3. Гэр	Хүч	Хүч	Хүч	Хүч	Хүч



Сурагчдын "Эрчим хүчний зохистой хэрэглээ" хичээлээр олж авсан мэдлэг чадварыг багш нар үнэлж дүгнэн үнэлгээний байдлыг эцэг эхэд танилцуулдаг.

Сурвалж	Тайлбар	Э. хэмн.	З. хэрэгл.	И. хэмн.	У. хэмн.
1. Гэр	Дэлгэрэнгүй тусгай материал	Хүч	Хүч	Хүч	Хүч
2. Гэр	Хүч	Хүч	Хүч	Хүч	Хүч
3. Гэр	Хүч	Хүч	Хүч	Хүч	Хүч

ТАЙЛАН БИЧСЭН: СУРГАЛТЫН МЕНЕЖЕР Д.МӨНХЗУЛ

Эрчим хүчний хэмнэлт, зохистой хэрэглээ хичээлийн тайлан

Нийслэлийн 114-р сургууль

“ЭРЧИМ ХҮЧ” хичээлийг ХГҮА хичээлээр 1-5 р ангиудад зохион байгуулав.

Агуулга нь :

- ЭРЧИМ ХҮЧНИЙ ТҮҮХ
- ҮЙЛДВЭРЛЭЛ
- ХЭРЭГЛЭЭ ХЭМНЭЛТ гэсэн сэдвийн дагуу 9 цаг орж сурагчид анхны мэдэгдэхүүнтэй болоод зогсохгүй цахилгааны үүрэг, цахилгааныг хэмнэх, аюулгүй үйл ажиллагааг баримтлах чадварыг эзэмшүүлсэн болно.

“БИД ИРЭЭДҮЙН ИНЖЕНЕР” зохион бүтээх тэмцээнийг STEM хөтөлбөртэйгээ интеграцчилан холбож 3-5 р ангиудын дунд зохион байгуулж **Салхин сэнс, Усан тээрэм, Нарны эрчим хүчний зай** бүтээж уралдав.

ЭРЧИМ ХҮЧЭЭ ХЭМНЭЖ ЭКО ОРЧИН бүрдүүлцгээе уралдааны үзэсгэлэнгээс

№	Зохион анги	1-р улирал	2-р улирал	3-р улирал	4-р улирал
1	1-р анги	Замын хөдөлгөөн	STEM	Эрчим хүч	Ном
2	2-р анги	Замын хөдөлгөөн	STEM	Ном	Эрчим хүч
3	3-р анги	STEM	Замын хөдөлгөөн	Эрүүл мэнд	Эрчим хүч
4	4-р анги	Замын хөдөлгөөн	Эрчим хүч	Ном	STEM
5	5-р анги	Эрчим хүч	Замын хөдөлгөөн	STEM	Ном



Эрчим хүчний хэмнэлт, зохистой хэрэглээ хичээлийн тайлан

Нийслэлийн 123-р сургууль

2018-2019 оны хичээлийн жилийн 3-р улиралд 1-5-р ангийн 19 бүлгийн 619 суралцагч долоо хоногийн 1 цагаар нийт 8 цагийн хичээлийг “Эрчим хүч – зохистой хэрэглээ” сэдвээр судаллаа.

Хүрэх үр дүн: Сэргээгдэх ба үл сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрээр цахилгаан эрчим хүчийг үйлпвэрлэн зөв зохистой ашиглах, түүний үр ашгийн үндсийг ойлгосноор сургууль дээрээ болон гэртээ эрчим хүчийг нэмнэж сурна.

Зорилго: Эрчим хүч хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх, хэмнэх үйл ажиллагааг хүүхдэд багаас нь зааж сургах, тэднээр дамжуулан эцэг, эх болон насанд хүрэгсдийн ухамсар, хандлагыг өөрчлөхөд оршино.

Суралцагчид хичээлийн явцад салхин сэнс, цахилгаан эрчим хүчээ хэрхэн хэмнэх вэ? гар зураг, бяцхан ном, зохион бичлэг зэрэг зүйлсийг хийлээ.

Эрчим хүчний зохицуулах хорооноос өгсөн гарын авлага, зурагт үзүүлэнгүүдийг багш нар сурагчдадаа таниулахаас гадна эцэг эхчүүддээ таниулж, зөвлөгөө өглөө. Сургуулийн мэдээллийн самбарт тавьж, олон нийтэд хүртээл болгосон.



4-5-р ангийн суралцагчдын дунд “Цахилгаан эрчим хүчээ хэрхэн хэмнэх вэ?” гар зургийн уралдаан зохион явуулав.




Дүгнэлт:

“Эрчим хүч-Зохистой хэрэглээ” хичээлийг үзэж судалснаар суралцагчид байгаль орчинд ээлтэй амьдрах, эрчим хүчээ хэмнэх, зөв зохистой зарцуулах арга барилд суралцлаа.

Эрчим хүчний хэмнэлт, зохистой хэрэглээ хичээлийн тайлан

Нийслэлийн 127-р сургууль

Сургалтын дагуу багш бүр хөтөлбөрөө батлуулж, хичээлээ заав. Сурагчдын хэрэглээ дээр түшиглэж, амьдрал ахуй, гэрийн хүмүүжил, эцэг эхийн хандлага төлөвшлийг хэрхэн өөрчлөх тал дээр сурагчдад ойлгуулж, хэрхэн хэмнэлт хийвэл улс эх орон, хувь айл өрхийн эдийн засагт хэмнэлттэй болохыг сурагчдад ойлгуулахыг зорилоо



Сургалтын менежер Ж. Чогсамба

Эрчим хүчний хэмнэлт, зохистой хэрэглээ хичээлийн тайлан

Нийслэлийн 129-р сургууль

2018-2019 оны хичээлийн жилийн 3-р улиралд “Эрчим хүч-зохистой хэрэглээ” сэдвээр ХГҮА-г зохион байгуулсан. 1-5 дугаар ангийн багш нар хөтөлбөр төлөвлөгөө боловсруулан, сурагчдад олгох чадварыг бүрэн эзэмшүүлсэн.

Багш нарын дунд хичээлээс гадуурх үйл ажиллагааны “Эрчим хүчний зохистой хэрэглээ-хэмнэлт” сэдвээр хэлэлцүүлэгт хичээл заагдлаа.

1-р анги багш В.Одгэрэл

2-р анги багш Ц.Болормаа

3-р анги багш Э.Очирханд, Н.Батчимэг нар

4-р анги багш О.Должинсүрэн, Л.Мөнхдэмбэрэл нар

5-р анги багш Э.Бадамханд, Б.Булган нар секцээрээ хамтран заасан.

3-5 дугаар ангийн сурагчдын дунд удирдамжийн дагуу зохион бичлэгийн уралдаан зарлан дүгнэсэн.

Уралдааны эхний шатны шалгаруулалтад нийт 120 гаруй зохион бичлэг ирсэн ба 2-р шатанд 21 зохион бичлэг шалгарсан.

1-р байрт- 3б Номуунцэцэг, 4а Д.Анхбаяр 5а Т.Цэнд-Аюуш

2-р байрт 3в Булгантамир 4б Ариунзул 5б Мичидмаа

3-р байрт 3б Амин-Эрдэнэ 4б Отгонгэрэл 5б Нарансолонго нар шалгарсан.



Эрчим хүчний хичээл орсноор багш, сурагчид эрчим хүчний үүслээс эхлээд, эрчим хүчний хэрэглээ ач холбогдол, эрчим хүчийг хэмнэх арга, хэмнэснээр айл гэрт болон улс оронд ямар ач тустайг ойлгуулан үр дүнтэй зохион байгууллаа.

Сургалын менежер Т.Энхбаяр

Эрчим хүчний хэмнэлт, зохистой хэрэглээ хичээлийн тайлан

Нийслэлийн 134-р сургууль

Манай сургууль нь нийт 20 багш 17 бүлэгтэй. Багш Ч.Басанзаяа, Ж.Ундраа нар нь “ХГҮА-Иргэний боловсрол” хичээлийн сургагч багшаар сургалтанд сууж нийслэлийн сургагч багшаар хичээл заасан ба эргэн сургуульдаа ирж багш сурагчдадаа тайлбарлан таниулж туршлага солилцсон.

Анги удирдсан багш нар 3-р улиралд хичээлээс гадуурх үйл ажиллагааны цаг дээр “Эрчим хүч”-ны талаар хөтөлбөр боловсруулан хичээлээ заалаа. Нийт 529 сурагч хамрагдав.



Тайлан бичсэн багш Ж. Ундраа

Эрчим хүчний хэмнэлт, зохистой хэрэглээ хичээлийн тайлан

Нийслэлийн 136-р сургууль

2019.02.11-нээс 2019.04.05-ны өдрийг хүртэл 8-10 цагийн агуулгыг 1-5 ангиудад “Эрчим хүчний зохистой хэрэглээ” сэдвийг дараах байдлаар үзэж судалсан.

Энэхүү хичээл нь сурагчдын хэрэгцээнд тохирсон өдөр тутмын үйл ажиллагаандаа хэрэгжүүлж болохуйц байснаараа сурагчдад илүү их сонирхолтой байсан.

1-2-р ангийн сурагчдад эрчим хүчний хэрэглээний талаарх ойлголтыг өгснөөр эрчим хүчээ хэмнэх аргад тэд илүү сайн суралцаж, түүнийгээ ахуй амьдралдаа хэрэгжүүлж байна.

Сургалтыг явуулахад гарсан давуу тал: Сурагчид эрчим хүчээ хэмнэх анхны мэдэгдэхүүн дээр тулгуурлан эрчим хүч хэмнэх энгийн аргуудаас суралцан түүнийгээ мөрдлөг болгож чадаж байгаа нь сургалтын давуу тал юм.

Сул тал нь: Гарын авлага, тараах материал байхгүй хүндрэлтэй байлаа.



Эрчим хүчний хэмнэлт, зохистой хэрэглээ хичээлийн тайлан

Нийслэлийн 137-р сургууль

3-5 дугаар ангийн нийт 267 суралцагчдад дараах хичээл сургалт ба бүтээлч ажлуудыг явууллаа. Мөн сургуулийн нийт 37 багш, ажилчид Дулаан, цахилгаан эрчим хүч үйлдвэрлэх станц–аас хүлээн авах танхимын ахлагч Б.Үүрцайх сургалтыг зохион байгуулсан.

1-2 дугаар ангийн сурагчдад эрчим хүч хэмнэх брошур, танилцуулгыг таниулах үйл ажиллагааг явуулсан. Нийт 6 бүлгийн 170 гаруй сурагчид хамрагдсан.

Дүгнэлт

3-р улиралд эрчим хүчний хичээл, үйл ажиллагааг явуулснаар суралцагчид эрчим хүчний талаар мэдлэг мэдээлэлтэй болж өөрийн гэрт, сургууль, ангидаа ус, цахилгаанаа хэмнэж сурч байна. Гэр ахуйн цахилгаан хэрэгсэлтэй зөв аюулгүй байдлаа ханган ажиллаж сурсан. Суралцагчдад цахилгааны талаар мэдээ мэдээлэл өгч, харилцан Эрчим хүчний усан тээрэм, уурын хөдөлгүүр, дулааны цахилгаан станцын түүхтэй танилцсан. Нарнаас эрчим хүч гаргаж авдгийг мэдэж, юунд ашигладаг болохыг судлав. Энгийн туршилтаар салхинаас эрчим хүч гарган авдаг болохыг батлав. Эрчим хүчний аюулгүй ажиллагаатай танилцаж, зөв зохистой хэрэглэхэд суралцав. Цахилгаан зарцуулалтын тухай ойлголт аваад түүнийг зөв зохистой хэрэглэж сурлаа. Эрчим хүчинд хэмнэлт хийх аргаас мэдэж авлаа. Байгалийн гэрлийг ашиглаж цахилгаанаа хэмнэхийн ач холбогдлыг ярилцсан. Мөн суралцагчдын дунд эрчим хүчээ хэмнэх гар зургийн уралдаан явууланаар тэдний мэдлэг мэдээллийг илүү бататгасан юм.

Нийтийн эзэмшлийн талбай болон ангийн гэрлийг тогтмол унтрааж, зөв ашиглах дадал, хэвшилтэй боллоо



Сургалтын менежер Д.Мөнхцэцэг

Эрчим хүчний хэмнэлт, зохистой хэрэглээ хичээлийн тайлан

Нийслэлийн 140-р сургууль

Хичээлийг 1,2,3,4-р ангиуд 7 хоног бүрийн ХГҮА н-ны цаг дээр, 5-р ангиуд амьдрах чадварын цаг дээр 7 хоногт 1 цагаар орсон.
1-5-р ангийн 361 сурагчид, 12 багш хамрагдлаа.



Тайлан бичсэн: ЗАН ахлагч Ш.Мөнгөнсаран

Эрчим хүчний хэмнэлт, зохистой хэрэглээ хичээлийн тайлан

Нийслэлийн 142-р сургууль

Сурагчдад эрчим хүч гэж юу вэ? түүнийг хэрхэн хэмнэх вэ? талаар ярилцахад маш сонирхолтойгоор анхаарч байсан ба одоогийн тогтвортой хөгжил гэх тодотголд нийцсэн, багаас нь хүүхдийг үүнд дасгах нь чухал юм байна гэсэн дүгнэлтэд хүрлээ. Эрчим хүч бол бидний амьдралын салшгүй хэсэг. Эрчим хүч манай дэлхий болон бидний амьдралд их, бага хэмжээгээр нөлөөлсөөр байдаг.

Сурагчдаас цахилгаанаа хэрхэн хэмнэдэг вэ? Гэхэд цахилгаан хэрэгслээ хэрэггүй үед асаадаггүй гэсэн боловч дараах зургийг тайлбартай нь ярилцахад хэдий унраадаг гэсэн оловч зурагтаа удирдлагаар нь унтраадаг утсаа, хөгжим сонсоод товчлуурыг нь дардаг, утсаа цэнэглэж дуусаад цэнэглэгчээ тэр хэвээр нь үлдээдэг гэх мэт ашиггүй зарлага гаргадаг болох нь гарч ирлээ.

Гэртээ байршуулсан хүүхдүүдийн төлөөлөл:



Эрчим хүчний хэмнэлт, зохистой хэрэглээ хичээлийн тайлан

Налайх дүүргийн Эрдмийн оргил цогцолбор сургууль

1-5-р ангийн 847 суралцагчдад “ Эрчим хүчний зохистой хэрэглээ” сэдвийн хүрээнд анги бүр өөрсдийн агуулгад тохирсон хөтөлбөрийг боловсруулж 9 цагийг сургалтыг зохион байгууллаа.

Дуслыг хураавал далай.

- ▶ Бид хойч үедээ ногоон ирээдүй үлдээх эрхэм зорилго чин хүсэлтэй. Дэлхий даяар эрчим хүчний хэмнэлт хийх олон ажил зохион байгуулагддаг. Тухайлбал
- ▶ Гэрлээ нэгэн зэрэг унтрааж энэ аянд нэгддэг. Мөн эрчим хүчээ хэмнэж ногоон байгалиа хамгаалдаг. Харин бид эрчим хүчний зохистой хэрэглээ хичээлийн хүрээнд дараах ажлуудыг зохион байгуулсан юм.

Дуулсныг хураавал эрдэм.

- ▶ Бид эцэг эхчүүддээ
- ▶ Эрчим хүчний хэмнэлт үр ашгийн тухай хичээл явуулан хэлэлцсэн юм. Тэд маань анхааран сонсож өөр өөрийн арга туршлагаа хуваалцаж байлаа. Тэдний зарим туршлага санаанаас дурьдвал
- ▶ Өмдөө индүү хэрэглэлгүй гудсан доороо хийгээд өмсөж болно гэж нэг өвөө саналаа хуваалцлаа.
- ▶ Хувцсаа өлгүүрт үргэлж өлгөж хадгалах нь индүүдлэг бага хийж тог хэмнэнэ гэж нэг ээж хэлэв.

Хамтдаа бүтээе

- ▶ Эцэг эхчүүд маань хамтран соруул картонон цаас ашиглан салхин сэнс хийсэн юм. Мөн эрчим хүчний үйлдвэр урлалаа.

Сургалтын агуулга

- ▶ Сургагч багш Э.Энхцэцэг М.Туул нар эрчим хүчний өртөөг хөтлөн явууллаа.
- ▶ Эрчим хүчний үйлдвэрлэл хэрэглээ
- ▶ Эрчим хүч хэмнэх арга замууд
- ▶ Бидний хийж чадах зүйлс
- ▶ Дулаан цахилгаан дамжуулах компаний инженер ааваар налайх дүүргийнхээ эрчим хүчний тухай яриулж, эцэг эхчүүдийн асуултад хариуллаа.


Эрчим хүчний хэмнэлт, зохистой хэрэглээ хичээлийн тайлан

Налайх дүүргийн Эрдмийн оргил цогцолбор сургууль

Сургалтаас эцэг эхчүүдийн мэдэж авч өдөр тутмын амьдралдаа хэвшүүлэх зүйлс

- Гэрлээ унтрааж хэвших
- Улайсдаг чийдэнгээс татгалзах
- Угаасан хувцсаа мушгиж салхинд хатаах
- Хөргөгчөө халуун газар байрлуулахгүй байх
- Цахилгаан хэрэгсэл бүрээ залгуураар нь салгах
- Масстай шалбархай утас тог их иддэг гэхчлэн олон зүйл сурч авлаа.

Бидний өнөөдрийн сонголт ирээдүйн өнгө




Сурагчдын дунд эрчим хүчний хэмнэлт сэдвийн хүрээнд АХА явуулсан.



- ▶ Сургуулийн коридор болон ангиудад танилцуулга плакатууд харагдах газар байрлуулсан.

Цахилгааны мөнгөө хэмнэе.

- ▶ Эрчим хүчний хэмнэлтийн өгөөжийн талаар хэлэлцэн 2-5-р ангийн сурагчид цахилгааны төлбөртөө судалгаа хийлээ.



Эрчим хүчний хэмнэлт, зохистой хэрэглээ хичээлийн тайлан

Оюуны ундраа цогцолбор сургууль

Эрчим хүчний хэмнэлт, зохистой хэрэглээ” хичээлийг сургалтын хөтөлбөрт оруулснаар:

1. Цахилгаан эрчим хүчийг хэмнэх нь ямар чухал, ач холбогдолтой, зөв зохистой хэрэглээ гэж юу болохыг сурагчдад ойлгуулж, өөрсдийн гэрийн цахилгаан эрчим хүчинд хэмнэлт гаргаж сурах.
2. Эрчим хүчийг хэмнэх замаар агаарын болон усны бохирдлыг бууруулж, ирээдүйдээ цэвэр сайхан орчин үлдээх.

✚ Энэ хичээлийг заахын тулд

- Эрчим хүчний үүсэл, түүх
- Эрчим хүчний үйлдвэрлэл
- Эрчим хүчний хэрэглээ ба хэмнэх аргууд нэсэн 3 бүлэг сэдвээ 1-5-р ангид тохируулан хуваарилсан.

✚ Анги тус бүрт нэгж ба ээлжит хичээлийн хөтөлбөр боловсруулж 3-р улиралд 8-9 цагийн хичээл заасан. 1-5-р ангид “Амьдрах чадвар”, “Хичээлээс гадуур үйл ажиллагаа” хичээлийн цаг дээр заасан.

✚ Хөтөлбөрүүдээсээ 1-ийн сонгож 5-р ангид “Хэрэглээ ба хэмнэлт” хичээлээр сургуулийнхаа багш нарт үзүүлэх хичээл заасан.

Нийслэлийн тэргүүний ОУЦС-ийн 1-5 анги ХГҮА цаг дээр "ЭРЧИМ ХҮЧНИЙ ЗОХИСТОЙ ХЭРЭГЛЭЭ" хичээл орох цагийн хуваарь 3 Улирал																			
№	Багшийн нэр	Анги	Лхагва						Пүрэв						Баасан				
			I	II	III	IV	V	VI	I	II	III	IV	V	VI	I	II	III	IV	V
1	Б.Адьяасүрэн	2-1.																	
2	С.Бумба	2-2.																	
3	Ц.Энхмаа	2-3.																	
4	Б.Дэлгэрмаа	2-4.																	
5	Б.Золжаргал	2-6.																	
6	Э.Сэржмядаг	2-5.																	
7	Ж.Мөнхцэцэг	3-1.																	
8	Сарангуа	3-3.																	
9	Ц.Гарамдагий	3-5.																	
10	Б.Гантуяа	3-8.																	
11	А.Хишгээ	3-10.																	
12	Гэрэлсүрэн	3-11.																	
13	Д.Оюунбилэг	4-2.																	
14	О.Энхмаа	4-5.																	
15	Л.Мөнхтуяа	4-6.																	
16	М.Норжинсүрэн	4-7.																	
17	Нарангарав	4-11.																	
18	М.Цэрэндулам	4-12.																	
19	Нарангарав	5-1.																	
20	О.Молорчимэг	5-2.																	
21	Ч.Оюун	5-5.																	
22	Г.Энхцэцэг	5-7.																	
23	Г.Уранбаяр	5-8.																	
24	Б.Болормаа	5-9.																	
25	Э.Дэчинноров	4-12.																	

“Эрчим хүч” Хичээлийн I ангийн тайлан

I ангид “Эрчим хүч” хичээлийг долоо хоногт 2 цагаар 18 цаг орсон.



Эрчим хүчний хэмнэлт, зохистой хэрэглээ хичээлийн тайлан

Оюуны ундраа цогцолбор сургууль

ХГҮА-Эрчим хүчний хичээл орсноор сурагчид ашиглаагүй сургууль болон ангийн гэрлийг унтраах, залгуурыг салгахад анхаардаг боллоо.



Эрчим хүчний хичээлээр салхин тээрэм, усан тээрмийн талаар мэдлэгтэй болж сэнс хийж сурч туршилт хийсэн.



Эрчим хүчээ хэмнэх санамжийг бичиж найзууддаа танилцуулж тайлагналаа.



Эрчим хүчний хэмнэлт, зохистой хэрэглээ хичээлийн тайлан

Оюуны ундраа цогцолбор сургууль



- Эцэг эхээс авах санал асуулгын хуудас
- 1- Танайх цахилгаандаа сард ойролцоогоор хэдэн төгрөг зарцуулдаг вэ? 80000 Төгрөг
 - 2- Жилийн аль саруудад бага цахилгаан хэрэглэгддэг вэ? 6-9 сар
 - 3- Цахилгааныг хэмнэх боломж бий юу? Бий
 - 4- Хөргөгчөө нээхээс өмнө юу авах гэж байгаагаа боддог уу? Тийш
 - 5- Угаалгын машинаа хэдээс хэдэн цагийн хооронд ашигладаг вэ? 5 өдөрөөс 6 өдөрөөс
 - 6- Компьютер болон зурагтаа ямар дарааллаар унтраадаг вэ?
 - A. Удирдлагаар
 - B. Залгуураар
 - C. Унтраах товчийг дарна. Тийш
 - D. Удирдлага залгуур
 - Д. Унтраах товч залгуур загаараар тийш
 - 7- Унтахдаа цахилгаан хэрэгслээ салгадаг уу? Үгүй
 - 8- Сүүн гэрэл энгийн гэрлийн алиныг нь хэрэглэдэг вэ? Энгийн
 - 9- Цахилгааны оргил ачааллын үе хэдийд гэж үзэж байна вэ? 17-19 цаг
 - 10- Ширээний гэрэлтүүдэг ашигладаг уу? Тийш

- Эцэг эхээс авах санал асуулгын хуудас
- 1- Танайх цахилгаандаа сард ойролцоогоор хэдэн төгрөг зарцуулдаг вэ? 20000
 - 2- Жилийн аль саруудад бага цахилгаан хэрэглэгддэг вэ? 5 сар, 3 сар
 - 3- Цахилгааныг хэмнэх боломж бий юу? Бий
 - 4- Хөргөгчөө нээхээс өмнө юу авах гэж байгаагаа боддог уу? Тийш
 - 5- Угаалгын машинаа хэдээс хэдэн цагийн хооронд ашигладаг вэ? 4 цагаас — 3 цагийн хооронд
 - 6- Компьютер болон зурагтаа ямар дарааллаар унтраадаг вэ?
 - A. Удирдлагаар
 - B. Залгуураар
 - C. Унтраах товчийг дарна.
 - D. Удирдлага залгуур
 - Д. Унтраах товч залгуур
 - 7- Унтахдаа цахилгаан хэрэгслээ салгадаг уу? Үгүй
 - 8- Сүүн гэрэл энгийн гэрлийн алиныг нь хэрэглэдэг вэ? Сүүн гэрэл
 - 9- Цахилгааны оргил ачааллын үе хэдийд гэж үзэж байна вэ? цагаас — 10 цагийн хооронд
 - 10- Ширээний гэрэлтүүлэг ашигладаг уу? Үгүй

Багш нараас авах санал асуулгын хуудас

1. Хөтөлбөрийн догуу хичээлээ заасан уу? Хөтөлбөрийн догуу хичээлийг заасан ба. Уан, үзүүлэлт, өмнөх ажлын үр дүнг заасан.
2. Хөтөлбөрт ямар өөрчлөлт оруулах саналтай байна. Нэгдсэн хөгжлийн хөтөлбөрийн д/х (дүр оруулах).
3. Нэмж оруулах зүйл байна үү? Хичээлд хэрэглэх гэрэлтүүдэг.
4. Сурагчид хичээлийг хэр сонирхож байна. Сүүлд хичээлийг маш их сонирхож д/аа.
5. Бэрхшээлтэй зүйл юу байна. “Дугуйн хичээлийг үйлдвэрлэл” хэрэглэх үзүүлэлт байхгүй. Иймээс зүүд, төлөв их зүйлээс байсан бол хичээлд ашиглахтай д/а д/аа болов уу? үзүүлэлт дүр хичээлдээ заав.


Багш нараас авах санал асуулгын хуудас

1. Хөтөлбөрийн догуу хичээлээ заасан уу? Хөтөлбөрийн догуу, үзүүлэлт, өмнөх ажлын үр дүнг заасан ба. Уан, үзүүлэлт, өмнөх ажлын үр дүнг заасан.
2. Хөтөлбөрт ямар өөрчлөлт оруулах саналтай байна. Ашиггүй хэрэглээний хөр. үр дүнийг дагуулан хичээлд оруулах.
3. Нэмж оруулах зүйл байна үү? Хичээлд хэрэглэх гэрэлтүүдэг, дагуулан, дагуулан өмнөх ажлын үр дүнг заасан.
4. Сурагчид хичээлийг хэр сонирхож байна. Сүүлд хичээлийг маш их сонирхож д/аа.
5. Бэрхшээлтэй зүйл юу байна. Ашиггүй хэрэглээний хөр. үр дүнийг дагуулан хичээлд оруулах.

Эрчим хүчний хэмнэлт, зохистой хэрэглээ хичээлийн тайлан


Оюуны ундраа цогцолбор сургууль

1. танайх цахилгаандаа сард ойролцоогоор хэдэн төгрөг зарцуулдаг вэ?




■ 10000-ын дотор ■ 10000-20000 ын дотор
■ 20000-40000 ын дотор ■ 50000-аас дээш


2. жилийн аль саруудад бага цахилгаан хэрэглэдэг вэ?




Угаалгын машинаар хэдээс хэдэн цагийн хооронд ашигладаг вэ?



КОМПЬЮТЕР БОЛОН ЗУРАГТАА ЯМАР ДАРААЛЛААР УНТРААДАГ ВЭ?




3. цахилгаан хэмнэх боломж бий юу?




■ тийм ■ үгүй

4. хөргөгчөө нээхээс өмнө юу авах гэж байгаагаа боддог уу?




■ тийм ■ үгүй ■ заримдаа

УНТАХДАА ЦАХИЛГААН ХЭРЭГСЛЭЭ САЛГАДАГ УУ?



СҮҮН ГЭРЭЛ ЭНГИЙН ГЭРЛИЙН АЛИНЫГ НЬ ХЭРЭГЛЭДЭГ ВЭ?



Эрчим хүчний хэмнэлт, зохистой хэрэглээ хичээлийн тайлан

Нийслэлийн Монгени сургууль

“ЭРЧИМ ХҮЧНИЙ ЗОХИСТОЙ ХЭРЭГЛЭЭ”- ХИЧЭЭЛИЙГ 1-5-Р АНГИД ДАРААХ ХӨТӨЛБӨРИЙН ДАГУУ СУДАЛЛАА.

№	Анги	Нэгж хичээлийн сэдэв	Хэрэгжүүлсэн анги, бүлэг	Хичээлийн үйл явц, үр дүн
1	I	<ul style="list-style-type: none">Эрчим хүч үүссэн түүх-2 цагҮйлдвэрлэл- 2цагЦахилгааны хэрэглээ ба хэмнэлт-5 цаг	1-а,б,в,г,д	<ul style="list-style-type: none">Гал, мод дулаан ялгаруулдаг болохыг мэдэж, ахуйн хэрэглээндээ хэрхэн хэрэглэдэг. Аюулгүй ажиллагааны дэгийг хэвшил болгов.Дэнгийн үүсэл хөгжлийг мэдэж авав.Нүүрсийг хэрхэн хэрэглэдгийг мэдэж, хэмнэх аргыг судлав.Уурын хөдөлгүүр, дулааны цахилгаан станц, нарны цахилгаан үүсгүүрийн тухай ойлголт өгсөн.Эрчим хүчээ хэмнэх 20 санамжтай танилцан, уриалга бичлээ.Цахилгаанаа хэрхэн хэмнэх талаар ярилцлага явууллаа.Байгалийн гэрлийн ач тусын тухай ярилцаж, сорил даалгавар ажиллаЭрчим хүчний хэрэглээний талаар өөрийн цуглуулсан сонирхолтой баримтаа найзууддаа уншиж өглөө.Салхин тээрэм, аюулгүй ажиллагаа, цахилгаан зарцуулалтын талаар мэдэж авав.Гэртээ цахилгаанаа хэрхэн зарцуулдаг талаар ярилцаж, зохион бичлэ хийв.Цахилгаан эрчим хүчийг хэмнэх аргыг сурагчдадаа ойлгуулснаар хүүхдүүдээр нь дамжуулан эцэг эх, насан хүрэгчдэдийг санаандгүй хэрэглээг зөв хэрэглэх, дадал хэвшил болгоход чиглэсэн. Жишээлбэл: гар утасны цэнэглэгчээ тогонд залгаатай нь орхих Олон залгуурны товчлуурыг нь дарж унтраахгүй орхих гэх мэт...
2	II	<ul style="list-style-type: none">Эрчим хүч үүссэн түүх-2 цагҮйлдвэрлэл- 2цагЦахилгааны хэрэглээ ба хэмнэлт-5 цаг	2-а,б,в,г,д	
3	III	<ul style="list-style-type: none">Эрчим хүч үүссэн түүх-2 цагҮйлдвэрлэл- 2цагЦахилгааны хэрэглээ ба хэмнэлт-5 цаг	3-а,б,в,г	
4	IV	<ul style="list-style-type: none">Эрчим хүч үүссэн түүх-2 цагҮйлдвэрлэл- 2цагЦахилгааны хэрэглээ ба хэмнэлт-5 цаг	4-а,б,в,г,д	
5	V	<ul style="list-style-type: none">Эрчим хүч үүссэн түүх-2 цагҮйлдвэрлэл- 2цагЦахилгааны хэрэглээ ба хэмнэлт-5 цаг	5-а,б,в,г,д,е	



Эрчим хүчний хэмнэлт, зохистой хэрэглээ хичээлийн тайлан

Дорнод аймаг

Аймгийн “Эрчим хүч хэмнэх дэд хөтөлбөр”-ийн хүрээнд 2019 оны 11 дүгээр сарын 6-7-ны өдрүүдэд эрчим хүчний зохицуулах зөвлөл, Боловсрол, соёл, урлагийн газраас хамтран зохион байгуулсан “Эрчим хүчний зохистой хэрэглээ” сургалтад Дорнод аймгийн ерөнхий боловсролын сургуулийн бага болон дунд ангийн 37 сургалтын менежер хамрагдав. Сургалтын менежерүүд сургалтад хамрагдсаны дараа 3861 сурагч, 328 багш ажилтан, 528 эцэг эхэд сургалтын мэдээллийг түгээн дэлгэрүүлсэн бөгөөд дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

Хэрлэн сумын 1 дүгээр сургууль: Анги удирдсан багш нар “Эрчим хүчний хэмнэлт-зохистой хэрэглээ” хөтөлбөрийн хүрээнд сурагчдад эрчим хүчний хэмнэлт, үр ашгийн талаар таниулах, түгээн дэлгэрүүлэх үйл ажиллагааг зохион байгуулж хичээл заалаа. Мөн зарим ангиуд эцэг эхчүүдийг урьж зөвлөгөө, мэдээлэл авсан байна.



Мөн сурагчид эрчим хүчийг хэрхэн хэмнэх аргуудын талаар мэддэг зүйлээ бусдадаа хуваалцаж, видео бичлэг болон хичээлээс ойлгосон зүйлээ зургаар илэрхийлэх, эх зохион бичих зэрэг үйл ажиллагааг зохион байгуулсан.

Анги удирдсан багш нар цахим группээр дамжуулан эрчим хүчний хэмнэлт, үр ашгийн талаарх мэдээллийг эцэг эхэд дамжуулж, анги танхим болон сургуулийн орчинд зурагт хуудсуудыг байрлуулсан.



Үр дүн: Сурагчид эрчим хүчийг хэмнэж, ухаалаг, зөв хэрэглээг нэвтрүүлснээр цахилгаан эрчим хүчинд төлөх мөнгөө хэмнэх ач тустайг ойлгосон. Эрчим хүчийг хэмнэснээр байгалийн нөөцийг хэмнэх, уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг өөрийн хувь нэмрээ оруулахыг ухамсарласан.



Эрчим хүчний хэмнэлт, зохистой хэрэглээ хичээлийн тайлан

Дорнод аймаг

Хэрлэн сумын 2 дугаар сургууль:

- Эрчим хүч хэмнэлтийн тухай хууль, засгийн газрын тогтоол, журмын эмхэтгэлийн талаар товч мэдээлэл
- Эрчим хүч хэмнэх үндэсний хөтөлбөр /2018-2020 он/-ийн хэрэгжилтийн талаар товч мэдээлэл
- Эрчим хүч-зохистой хэрэглээ
- 2018 онд 1-5 дугаар ангид Эрчим хүчний зохистой хэрэглээ 9 цагийн сургалтыг Налайх, Багахангай, Улаанбаатар хотын сургуулиудад туршиж сургалт зохион байгуулсан бичлэгүүдэд бага ангийн багш нар анализ хийж дадлага ажил хийлээ.
- “Эрчим хүчийг зохистой хэрэглээ” уриалга гаргаж хүн бүр гэр бүлдээ, ажил дээрээ хэрэгжүүлж ажиллахаар боллоо.

Хэрлэн сумын 12 дугаар сургууль: Сургалтад тараагдсан боршур, гарын авлага, зурагт хуудсыг сургууль, анги танхимын коридорт байрлуулсан.



Бага ангийн эцэг эхчүүдэд “Эрчим хүчээ хэмнэх энгийн арга” сэдвээр сургалт мэдээллийг 2019 оны 12 сарын 14-ний өдөр зохион байгуулсан. Нийт 135 эцэг эх хамрагдсан.



Сургуулийн нийт багш ажилчдад 2019 оны 12 дугаар сарын 24-ний өдөр “Өөрийн амьдарч буй гэр орныхоо гэрэл чийдэнг хэрхэн зөв зохистой хэрэглэх вэ” сэдвээр анхан шатны мэдээлэл өгч секцийн ахлагч нарт боршур, зурагт үзүүлэн тарааж өгсөн. Нийт 69 багш ажилчид хамрагдсан.

Эрчим хүчний хэмнэлт, зохистой хэрэглээ хичээлийн тайлан

Дорнод аймаг

Хэрлэн сумын Шинэ хөгжил цогцолбор сургууль: 2019 оны 12-р сарын 20-ны өдөр 9-р ангийн 4 бүлгийн 117 сурагчдад физикийн багш нартай хамтран “Цахилгаан эх үүсвэр ба гүйдлийн урсгал” сэдвээр хичээлийг зохион байгуулж цахилгаан хэмнэх талаар туршилт хийлгэж, “Цус сорогч” буюу цахилгаан хэрэглээгүй үед залгуурын гэрэл асч байдгаас цахилгаан бага хэмжээгээр гүйж цахилгаан тоолуур урсаж байдаг гэдгийг хэлж өгсөн нь илүү түлхүү сонирхолтой болж өгсөн. 6-8 дугаар ангийн 405 сурагч, 10-11 дугаар ангийн 110 сурагч, дунд ахлах ангийн 30 багшид “Эрчим хүчээ хэмнэх” сэдвээр дунд ангийн эцэг эхчүүдийн төлөөлөл 15 хүнд “Гэрлийн мөнгө тооцоолох” талаар мэдээлэл олгосон. Энэ мэдээлэлд нийт 632 сурагч, 30 багш, 15 эцэг эх хамрагдсан байна.

Хэрлэн сумын Долоодой сургууль: Суралцагчдад “Өрхийн эрчим хүчийг хэмнэх, зохистой хэрэглэх арга зам”-ийг таниулах, мэдлэг олгох зорилгоор Монгол улсын зөвлөх инженер Батжаргалыг урьж сургуулийн нийт суралцагчдад сургалт зохион явууллаа. Сургалтад 1-12 дугаар ангийн 53 суралцагч, 4 багш хамрагдав. Сургалтыг хэмнэлттэй чийдэн, хуучны тунгалаг шилтэй уламжлалт чийдэн хэрэглэхээс татгалзаад эрчим хүч хэмнэгч чийдэн хэрэглэдэг болох



1. Гэрлээ унтраах

Өрөө болон албан тасалгаанаас гарахдаа гэрлээ унтрааж хэвших

2. Цэгэн гэрэлтүүлэг

Оройн цагаар хичээлээ давтаж суухдаа өрөөний гэрэлтүүлэг хэрэглэхээс татгалзаж ширээний гэрэл ашиглаж хэвших

3. Эрчим хүчний хэмнэлтийн зэрэглэл

Орчин үеийн цахилгаан хэрэгсэлд цахилгаан хэмнэлтийн зэрэглэлийн тэмдэглээ байдаг бөгөөд А++ хамгийн хэмнэлттэй тэмдэглэгээ бөгөөд хэмнэлт үсгийн дарааллаар буурсаар G тэмдэглэгээ цахилгааны хортой хог хаягдал гэдгийг таниулав. Цахилгаанаар ажилладаг эд зүйлс худалдан авахдаа А,В,С,Д,Е,Ғ зэрэглэлийг харж сонголт хийж хэвших

Эрчим хүчний хэмнэлт, зохистой хэрэглээ хичээлийн тайлан

Дорнод аймаг



Хэмнэлтийн горим

Гар утсаа цэнэглэж дууссаны дараа цэнэглэгчээ залгуураас заавал салгах, гар утасны тоглоом бага тоглож утасны цэнэгээ хэмнэх, зурагтыг удирдлагаар унтраан тэжээлийн залгуурыг салгаж байх, нөтбүүк түр ашиглахгүй байх хугацаандаа хавтсыг хааж хүлээлтийн горимд шилжүүлэх, гэрээс гарахдаа интернэт модемыг унтраах, тарифт тоолууртай бол 21.00-06.00 цагийн хооронд угаалгын машин, тоос сорогч ажиллуулах, халуун хүнсний зүйлсийг тасалгааны температур хүртэл хөргөж байж хөргөгчинд хийх, усыг хэрэглэх хэмжээндээ тохируулан буцалгах зэргээр цахилгаан хэмнэж хэвших

4. Олон тарифт тоолуур

Шөнийн цагаар цахилгааны үнэ хамгийн хямд байдаг ба үүнийг мэдэрдэг шөнө, өдрийн гэсэн хоёр тарифтай тоолуур байдаг бөгөөд ийм тоолуурыг ашиглах зэрэг агуулгыг танин мэдэх, ойлгуулах түвшинд тайлбарлан ярих, харилцан ярилцах аргачлалаар зохион явууллаа. Сургалтын үр дүнд суралцагчид маань цахилгааны хэмнэлтийн талаар ойлголттой болж, сургуулийн орчинд анги танхимаас гарахдаа тогоо унтрааж хэвшээд байна.

Булган сумын сургууль: Хүүхдийн оролцооны байгууллагын сурагчид, эцэг эхийн хорооны гишүүд, хүүхдийн элч Д.Пунсалдулам, нийгмийн ажилтан А.Номин нар байгууллагын гадаад, дотоод орчны эрсдэлийн үнэлгээг хийж, дүгнэлтийн дагуу эрсдэлийг бууруулах ажлуудыг зохион байгуулсан. Үүнд: разетик, унтраалганы хажууд тэмдэг тэмдэглэгээ хангалтгүй байсныг 1а ангийн эцэг эхийн зөвлөл “Цахилгаанаа хэмнэе” наалтуудыг бүх өрөө тасалгаанд байршуулсан. Эко клубын сурагчид, 45 эцэг эх, дунд ангийн 32 сурагчдад “Цахилгаанаа хэмнэе” брошурыг тарааж мэдээлэл түгээж ажилласан. Сургуулийн мэдээллийн самбарууд болон сургуулийн цахим хаягаар эцэг эх олон нийтэд зориулсан “Эрчим хүчээ хэмнэе” 3 төрлийн 7 ширхэг материалыг байршуулсан.

Эрчим хүчний хэмнэлт, зохистой хэрэглээ хичээлийн тайлан

Дорнод аймаг

Баян-уул сумын сургууль: Эрчим хүчний хэмнэлтийн талаар дараах асуулгын хүрээнд тандалт судалгаа авч, үр дүнг нэгтгэн дүгнэж ажиллав. Үүнд:

1. Эрчим хүчний хэмнэлтийн тухай хууль хэдэн онд батлагдсан бэ? \ 100% мэдэхгүй гэж хариулсан\
2. Танайх гэртээ аль гэрлийг ашигладаг вэ?
А. Улайсдаг гэрэл - үгүй Б. Сүүн гэрэл- 90% В. Лед гэрэл- 10%
1. Та гар утасны цэнэглэгчээ ашиглаагүй үедээ салгадаг уу?
А. Тийм- 96,8% Б. Үгүй- 3,2%
1. Та TV унтраахдаа залгуураар нь салгадаг уу?
А. Тийм – 68,7% Б. Үгүй – 31,3%
1. Танай цахилгаан хэрэгслүүд хэмнэлттэй юу?
А. Тийм - 40,6% Б. Мэдэхгүй- 53,1% В. Үгүй – 6,2%
1. Та цахилгаан хэрэгсэл дээрх шошгийг ойлгодог уу?
А. Тийм – 50% Б. Үгүй- 50%
1. Та цахилгаан хэрэгсэл худалдаж авахдаа хэмнэлттэй эсэхийг нь тооцдог уу?
А. Тийм – 56,2% Б. Үгүй – 43,7%
1. Та өрхийн цахилгаанаа хэмнэх талаар санаачлага гаргадаг уу?
А. Тийм- 93,7% Б. Үгүй – 6,3%
1. Сургууль бол бидний хоёр дахь гэр гэдэгтэй та санал нийлэх үү?
А. Тийм – 100% Б. Үгүй
1. Цахилгаанаа хэмнэх нь ямар ач тустай вэ? \ 3 –аас доошгүй бичих\
 - Байгаль орчинд ээлтэй
 - Эдийн засагт хэмнэлттэй
 - Зөв дадал хэвшил, соёл, хандлага төлөвшинө.
 - Үр дүнгүй зардлаа хэмнэнэ.
 - Эрүүл мэндээ хамгаална.
 - Аюулгүй байдал хангагдана.
 - Аливаа зүйлийг хэмнэх дадал төлөвшинө.

Ирээдүй хойчийн төлөөх том хөрөнгө оруулалт болно гэсэн хариулт өгсөн байгаагаас харахад цахилгааны хэмнэлт гэдэг бол эдийн засаг, байгаль орчинд нөлөөлөөд зогсохгүй маш олон эерэг зүйлийг авчирдаг болох нь ажиглагдлаа. Дээрх судалгааны дүнгээс харахад эрчим хүчний хэмнэлтийн боловсрол дутмаг байгаа нь ажиглагдсан тул “Эрчим хүчний хэмнэлт–зохистой хэрэглээ” сургалт, мэдээллийг сургуулийнхаа 52 багш, ажилтанд хийсэн. Багш нараар дамжуулан сурагчид болон тэдний гэр бүлд нөлөөлөх замаар эрчим хүчний хэмнэлтийн боловсрол эзэмшүүлэх зорилгоор сургалт зохион байгуулсан.

Үр дүн: Өрхийн болон байгууллагын сарын цахилгааны төлбөрийн мэдээлэл авч, “Цахилгаанаа хэмнэцгээе” сарын аян зарлаад, үйл ажиллагааг дүгнэхээр төлөвлөсөн байна.

Эрчим хүчний хэмнэлт, зохистой хэрэглээ хичээлийн тайлан

Дорнод аймаг

Гурванзагал сумын сургууль:

Д/д	Зорилт	Хэрэгжилт, үйл ажиллагаа
1	Эрчим хүч хэмнэх үндэсний хөтөлбөрийн	“Эрчим хүчээ хэмнэх аргууд” сэдвийн хүрээнд зурагт самбаруудаар мэдээлэл бэлтгэн, анги танхимуудад байршуулж, сургуулийн нийгмийн ажилтан анги удирдсан багш нартай хамтран 1-9 дүгээр ангийн 151 сурагчдад “Иргэний ёс зүйн боловсрол” үйл ажиллагааны цагт багтаан мэдээлэл хүргэлээ.
2	4.6.”Эрчим хүч хэмнэлт, үр ашигтай	Сургуулийн албан ёсны цахим хуудсаар дамжуулан “Эрчим хүчээ зохистой хэрэглэцгээе” мэдээлэл тавьж, сурагчид, эцэг эхчүүд олон нийтийг уриалсан.
3	хэрэглээний талаарх хичээлийг бүх шатны	“Эрчим хүчээ зохистой хэрэглэцгээе” цахим хуудасны нүүр зурагны хүрээ хийж, олон нийтийг эрчим хүчээ зохистой хэрэглэцгээе challenged уриалсан.
4.	боловсролын байгууллагын сургалтын хөтөлбөрт тусгах, олон нийтэд чиглэсэн мэдлэг, мэдээллийг түгээх замаар эрчим хүчний зохистой хэрэглээг бий болгож төлөвшүүлэх	<p>Эрчим хүч хэмнэлт, үр ашигтай хэрэглээний талаарх мэдээллийг байгууллагын мэдээллийн цаг дээр багш, ажилчдад хүргэсэн. Нийт 31 багш ажилчин хамрагдсан. Үүний үр дүнд:</p> <ul style="list-style-type: none"> ✓ Ажлын байран дээрх эрчим хүч хэмнэлтийг хэвшил болгож эхэлсэн. Жишээлбэл: Багш нар анги, танхим, өрөө тасалгаанаас гарахдаа гэрлийг заавал унтрааж хэвшиж байна. Мөн канон, принтер, люминаторын машин, утасны цэнэглэгч г.м-ийг хэрэглэсэн даруйдаа бүрэн унтраах дадал хэвшилд суралцаж байна. ✓ Сургуулийн коридорын бүх гэрлүүдийг сүүн гэрлээр сольсон. ✓ Сургуулийн дулаан алдагдалтай хэсгийг олж тогтоон дулаалах ажлыг няраваар удирдуулсан ажлын хэсэг тогтмол хийж байна.

Цаашид анхаарах, хийж хэрэгжүүлэх ажлууд:

- Сургуулийн “Эко элч” бүлгэмийн сурагчдыг “Эрчим хүчний зохистой хэрэглээ, хэмнэлт” сургалтад хамруулан чадавхжуулах, тэднээр дамжуулан сурагчдад эрчим хүчний зохистой хэрэглээний боловсрол олгох
- “Иргэний ёс зүйн боловсрол” үйл ажиллагааны цагийн 5-10 минутад сурагчдад энэ чиглэлийн мэдлэг, мэдээлэл олгох
- Сумын “Эрчим хүчний тасаг” болон сумын байгаль хамгаалагч нартай хамтран сурагчид болон иргэд, олон нийтэд эрчим хүчний зохистой хэрэглээний талаарх ойлголт, мэдээлэл өгөх нөлөөллийн олон талт ажил зохион байгуулах
- Ажлын байр, анги танхимд эрчим хүчний зохистой хэрэглээний санамж бичиг байрлуулах

Эрчим хүчний хэмнэлт, зохистой хэрэглээ хичээлийн тайлан

Дорнод аймаг

Дашбалбар сумын сургууль: Сургалтын түгээн дэлгэрүүлэлтийг сургуулийн хэмжээнд багш, удирдах ажилтнууд, дунд анги, ахлах ангийн сурагчдад 3 үе шаттай зохион байгуулсан. Сургалтын материалыг <http://ecc.gov.mn> цахим сайтаас татаж, багш нар, сурагчдад зориулсан мэдээлэл боловсруулан бэлтгэн багаар ажиллуулах, дадлага ажил хийлгэх, сорил асуулга бөглөх, бичлэг, зурагт үзүүлэн харуулах зэргийг сургалтад ашигласан.

26 багш, удирдах ажилтан нарт сургалт, мэдээллийг хүргэж, дунд ангийн сурагчдыг бүлэг тус бүрээр зохион байгуулж, 5 бүлгийн 144 сурагч, ахлах ангийн 5 бүлгийн 106 сурагч буюу нийт сурагчдын 91,9 хувийг хамрууллаа.

Сургалтын үр дүнд: Бид ашиглаж буй хэрэглээнээс хамаарч эрчим хүчийг хэмнэж өрхийн болон төсвийн хэмнэлт хийж болох талаар мэдлэг нэмэгдсэн.

- Орчин үеийн дэвшилтэт технологи ашигласан тоног төхөөрөмж, техник хэрэгслийг худалдан авах талаар мэдлэг олж авсан.
- Цахилгаан хэрэгсэл зөв зохистой ашиглах талаар сурагч, анги бүр ангидаа, гэртээ мөрдөх дэг боловсруулсан.
- Сургалтад амжилттай оролцсон багш, сурагчдыг гарын авлага, зурагт хуудас, ангид байрлуулах хичээлийн хуваариар урамшуулсан.

Цаашид:

- Бага ангид хичээл заах хөтөлбөр төлөвлөгөө боловсруулах бэлтгэл хангах
- Бага ангид 9 цагийн хичээл заана.
- Дунд ангийн сурагчид ангидаа мөрдөж гаргасан уриалга, гэртээ хэрэгжүүлж буй хэмнэлтийн талаар гарсан үр дүнг хүүхэд бүр зохион бичлэгээр илэрхийлэх
- Ахлах ангийн сурагчид ангидаа мөрдөж гаргасан уриалга, гэртээ хэрэгжүүлж буй хэмнэлтийн талаар гарсан үр дүнг хүүхэд бүр эсээ бичлэгээр илэрхийлэх
- Эрчим хүчний зохистой хэрэглээг хэвшүүлэх талаар сургууль, дотуур байр, спорт зааланд байрлуулсан зурагт хуудсыг мөрдөж, зөв ашиглалтад хэвшил болгох



Эрчим хүчний хэмнэлт, зохистой хэрэглээ хичээлийн тайлан

Дорнод аймаг

Сэргэлэн сумын сургууль: Эрчим хүчийг зөв зохистой хэрэглэх нь хүн бүрийн хувьд чухал асуудал болохыг ойлгохоос гадна байгууллага болон гэр бүлийн орчиндоо эрчим хүчний маш их үргүй зардал гаргадаг бөгөөд тэр үйлдэлдээ ач холбогдол бага өгдөг байсан талаараа дүгнэн ярилцсан. Мөн цахилгаан бараа худалдан авахдаа юуг анхаарах ёстой, зарим таних тэмдгүүдийг ямар зориулалтайг нь мэддэггүйг гарын авлагууд дээрээс ойлгож мэдсэн. Сургуулийн дотуур байрны сурагчдад “Эрчим хүчний зохистой хэрэглээ” сэдэвт сургалт зохион байгуулсан. Сургуулийн мэдээллийн самбаруудад “Эрчим хүчний зохистой хэрэглээ”-ний талаар зурагт хуудас, гарын авлагуудыг байрлуулснаар иргэд олон нийтэд мэдээллийг нээлттэй хүргэсэн.

Үр дүн: Дотуур байрны сурагчид эрчим хүчний зохистой хэрэглээнд суралцаж тог цахилгааны мөнгөө хэмнэх боломжтой, мөн сургалтын үеэр сурч мэдсэн зүйлээ эцэг эх, гэр бүлийн гишүүд, найз нартаа зөв мэдээлэл түгээх хүсэл эрмэлзэлтэй болсон.

Цаашид: Бага ангийн ЗАН-ээр “Эрчим хүчний зохистой хэрэглээ” сэдвийн хүрээнд 3-р улирлын ажлын төлөвлөгөөндөө 7-14 хоногийн хугацаанд аян зарлах, багш зохицуулах цаг, хүмүүжлийн ажлын цагуудаар тодорхой сэдвүүдийг заахаар төлөвлөж байна.

Цагаан-овоо сумын сургууль:

- Эрчим хүчний хэмнэлтийн тухай хууль
- Монгол Улсын Засгийн газрын тогтоолоор батлагдсан “Эрчим хүч хэмнэх үндэсний хөтөлбөр”
- Үүрэг хүлээсэн хэрэглэгчийн эрчим хүчний жилийн хэрэглээний босго хэмжээ
- Эрчим хүчний аудитор, эрчим хүч хэмнэлтийн менежер бэлтгэх сургалтыг зохион байгуулах, гэрчилгээ олгох, хүчингүй болгох журам зэргийг танилцуулсан.

Мөн анги удирдсан багш нараар дамжуулан “Эрчим хүчний хэмнэлт зохистой хэрэглээ” сэдвээр Дорнод аймгийн эрчим хүчний зохистой хэрэглээ ФВ хуудаснаас мэдээлэл авч 400 гаруй сурагч, 50 гаруй эцэг эхчүүдэд мэдээлэл өгч ажиллав. Сургалтаар гэр бүл болон ажлын байрандаа гэрэл дулааныг хэрхэн зөв зохистой хэрэглэж хэвшиж сурах талаар өрх гэртээ хэмнэлт өртгийн тооцоололтой болоход дэмжлэг үзүүлэх зорилгоор мэдээлэл өгч ажиллав.

Эрчим хүчний хэмнэлт, зохистой хэрэглээ хичээлийн тайлан

Дорнод аймаг

Чулуунхороот сумын сургууль: Бага ангийн 181 сурагчдад “Эрчим хүчний хэмнэлт зохистой хэрэглээ” сургалтаар цахим хичээлүүдийг ашиглан зохион байгуулав. Эцэг эхчүүдийн сэтгэл ханамж өндөр байлаа. Эрчим хүчний хэрэглээний талаар 5 асуулт бүхий судалгаа 2-5 дугаар ангийн сурагчдаас авч дүнг нэгтгэв.

1. Танайх гэрлээ унтраадаг уу. Унтраадаг-79%
2. Залгуураа салгадаг уу? Салгадаг-38%
3. Өдрийн гэрэл хэрэглэдэг үү? Өдрийн гэрэл хэрэглэдэг-76%
4. Телевизороо яаж унтраадаг вэ? Удирдлагаар нь унтраадаг-60%
5. Гэрээсээ гарахдаа цахилгаан хэрэгсэлээ салгаж гардаг уу? Салгадаг-70%

Судалгаанаас харахад ихэнх айл цахилгаан эрчим хүчээ хэмнэх талаар бага мэдлэгтэй байна.

Анги тус бүр хөтөлбөрийн дагуу 9 цагийн сургалтыг явуулав. Хүүхдэд энэ төрлийн мэдлэг бага байсан нь сургалтын явцад харагдаж байсан. Танин мэдэхүйн түвшинд 4-5 ангийн сурагчид идэвхтэй оролцож, эрчим хүчээ хэмнэх талаар дадал хэвшилд суралцлаа. Сургалтын үр дүнг 5 асуултаар дүгнэв.

1. Танай гэрийнхэн цахилгаанаа хэмнэдэг үү? Хэмнэдэг-96%
2. Чи орой гэрлээ унтраадаг уу? Унтраадаг-95%
3. Танай гэрийнхэн утсаа цэнэглэж дуусаад цэнэглэгчээ салгадаг уу? Салгадаг-100%
4. Танайх гэртээ ямар гэрэл хэрэглэдэг вэ? Өдрийн гэрэл, лед хэрэглэдэг-80%
5. Ангийнхаа гэрлийг тогтмол унтрааж сурсан уу? Тогтмол унтраадаг-100%

Эрчим хүчээ хэмнэх талаар дараах зөвлөмжийг сурагчдаар гаргуулав.

- Чи гэрэл цахилгаанаа хэмхэн талаар найздаа зааж өгөөрэй.
- Чи гэрийнхэндээ гэрлээ унтраа гэж тогтмол хэлж сурсан уу?
- Явал цахилгаан хэмнэх талаар сайн бодоорой.

Эрчим хүчний хэмнэлт, зохистой хэрэглээ хичээлийн тайлан

Дорнод аймаг

Халхгол сумын сургууль: Сургуулийн хэмжээнд 374 сурагчдад эрчим хүчний талаар мэдээлэл өгч, сурагч бүр эрчим хүчээ хэмнэхэд хэрхэн хувь нэмрээ оруулах, ямар тохиолдолд эрчим хүчний алдагдал үүсэх талаар ярилцаж санал бодлоо солилцлоо. Сургалтад ангиуд 100 хувь хамрагдсан байна.

1а-28 сурагч	3а-23 сурагч	5а-35 сурагч	9а-23 сурагч
1б-29 сурагч	3б-24 сурагч	6а-35 сурагч	10а-25 сурагч
2а-21 сурагч	4а-25 сурагч	7а-27 сурагч	11а-11 сурагч
2б-16 сурагч	4б-19 сурагч	8а-22 сурагч	12а-11 сурагч

Сургалтаар Эрчим хүч хэмнэлтийн тухай хууль"-ийн 9.1.7. “Эрчим хүчийг хэмнэх, үр ашигтай хэрэглээний талаар нийтэд сурталчлах, танин мэдүүлэх ажлыг зохион байгуулах” зорилт, “Эрчим хүч хэмнэх үндэсний хөтөлбөр”-ийн

4.6. “Эрчим хүч хэмнэлт, үр ашигтай хэрэглээний талаарх хичээлийг бүх шатны боловсролын байгууллагын сургалтын хөтөлбөрт тусгах, олон нийтэд чиглэсэн мэдлэг, мэдээллийг түгээх замаар эрчим хүчний зохистой хэрэглээг бий болгож төлөвшүүлэх” зорилт

4.6.1. Эрчим хүч хэмнэлтийн үр ашиг, ач холбогдлын талаарх мэдлэгийг иргэд олон нийтэд сурталчлах, мэдээллээр хангах, сургалт зохион байгуулах, ажлыг хэрэгжүүлэх, эрчим хүчийг хэмнэх үндэсний өдөртэй болох

4.6.2. Эрчим хүч хэмнэлт, зохистой хэрэглээний чиглэлээр хичээлийг ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрт тусгах арга хэмжээ авах, ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад эрчим хүчний хэмнэлт, үр ашигтай хэрэглээний талаар сурталчлан таниулах, тэдэнд зөв дадал хэвшүүлэх ажлыг хамтран хэрэгжүүлэх зорилтуудын дагуу болон сургалт сурталчилгааны ажлыг иргэдийн насан туршдаа сурч боловсрох үүрэг хариуцлагын хүрээнд зохион байгуулах шаардлагатай хэмээн үзэж сурагч багш бэлтгэн үйл ажиллагаагаа жилийн турш тогтвортой хэрэгжүүлэхээр болсны дагуу бүх ангийн сурагчдад энэ талаар мэдээлэл өгөх ажил зохион байгуулснаас гадна бага ангийн хөтөлбөрийн дагуу ордог сэдвийн дагуу цахимаас хөтөлбөрүүдийг бэлнээр татан авч хөтөлбөрийн сан үүсгэсэн.

Эрчим хүчний хэмнэлт, зохистой хэрэглээ хичээлийн тайлан

Дорнод аймаг

Мэдээлэл сургалтад нийт 374 сурагчид хамрагдаж, сургалтын эхэнд сурагчдаас судалгаа авч, нэгтгэлийг дүгнэвэл:

№	Асуулга	Асуулгын нэгтгэл			График
1	Эрчим хүч хэмнэлтийн тухай хууль 2015 онд батлагдан хэрэгжиж байгааг та мэдэх үү?	228	142		
2	Та гэрийнхээ цахилгааныг хэмнэх талаар санаа тавьдаг.	317	28	29	
3	Та өөрийгөө эрчим хүч хэмнэх талаар хэр мэдлэгтэй гэж бодож байна вэ?	344	30		
4	Та эрчим хүчийг хэмнэх талаарх мэдээллийг хаанаас авдаг вэ? /хэдийг ч дугуйлж болно/	142	115	56	
5	Танай гэрт эрчим хүчний хэмнэлттэй цахилгаан хэрэгсэл бий юу?	224	112	37	
6	Та цахилгаан хэрэгслийн эрчим хүч хэмнэлтийн тэмдэглэгээ /шошго/-ний талаар мэдэх үү?	258	116		
7	Та цахилгаан хэрэгсэл худалдан авахдаа эрчим хүчний хэмнэлттэй эсэхийг харгалздаг уу?	172	116	86	
8	Эрчим хүчний хэмнэлт хийхэд танд юу шаардлагатай байна вэ?	258	116		
9	Эрчим хүчээ хэмнэснээр танд ямар ач тустай гэж үзэж байна.	202	142	30	

Судалгаанаас дүгнэхэд сурагчдын ихэнх хувь нь эрчим хүчний тухай хууль гарсан эсэх хэмнэлтийн талаар мэдээлэл дутмаг байлаа. Мэдээлэл өгсний дараа сурагчдын хандлага өөрчлөгдөж сэтгэл ханамж сайн байгаа нь тэдний ярианаас харагдаж байлаа.



Сурагчдад өдөр тутмын амьдралдаа хэвшил болгох зорилгоор дараах нөлөөлөх ажлыг зохион байгууллаа. Анги танхимын унтраалга болгоны доор мөн хананд мэдээллийг наан байрлуулж өдөр бүр хэвшүүлэх даалгавар өглөө.



Эрчим хүчний хэмнэлт, зохистой хэрэглээ хичээлийн тайлан


Дорнод аймаг

энгийн аргуудаар тараах материал 100 ширхэгийг бэлтгэн сургалт мэдээллээр бүгд 500 материал боловсруулан хүргэлээ.



Сурагчдаар дамжуулан эцэг эх, иргэдэд түгээн дэлгэрүүлэх үйл ажиллагааг зохион байгууллаа. Нийт 368 хүүхдийн эцэг эхэд мэдээлэл сурталчилгааг хүргэж уриалга, санамж тараан гарын үсгийн баталгаа авлаа.

Түүнчлэн тус сургуулиас сумын хэмжээнд хамтран ажилладаг албан байгууллагуудын дунд “Эрчим хүчний хэмнэлт, зохистой хэрэглээ” сэдвээр мэдээлэл, сурталчилгааны ажил зохион байгууллаа. Уг нөлөөллийн ажлын хүрээнд сургагч багшаар бэлтгэгдсэн сургалтын менежер Р.Дагийсүрэн ажлын удирдамж боловсруулан сумын засаг даргаар батлуулан, суралцагч, иргэд, албан байгууллагын дэг, журамд эрчим хүчний хэрэглээний зөв дадал хэвшүүлэх ажилд тодорхой ахиц гаргах зорилгоор эргэх холбоотой ажиллахыг уриалж, зөвлөмж, гарын авлага олшруулан тараасан.



Эрчим хүчний хэмнэлт, зохистой хэрэглээ хичээлийн тайлан

Дорнод аймаг

Энэ чиглэлээр хийсэн ажлын талаарх мэдээллийг албан байгууллагуудаас гадна хүүхдээр дамжуулан айл өрхүүдэд хүрч ажилласан. Сургалт мэдээллийн агуулга өргөн байсан тул багш нар агуулгаа сонгон, дадлага ажиллуулах, зөвлөгөө өгөх зэргээр өөр өөр агуулга, арга зүйгээр ажилласан.

Энэ удаагийн мэдээллээр багш нар хуваарийн дагуу албан байгууллагууд дээр ажиллан, төрийн албан хаагчдын энэ талаарх ойлголтыг тандсан асуулга авсан ба асуулгын нэгтгэлээс харахад нийт төрийн албан хаагчид эрчим хүчний хэрэглээний талаарх мэдлэг, хандлага төдийлөн сайн биш байгаа нь цаашдаа энэ талаарх хандлагаа өөрчлөх хэрэгтэйг сануулж байна.

Сургалтаар “Эрчим хүчний үндэсний хөтөлбөр”, Эрчим хүчний тухай хууль, эрчим хүчний зохистой хэрэглээний талаар энэ хичээлийн жилээс эхлэн 1-5 дугаар ангийн хичээлийн хөтөлбөрт тусгагдсан сэдвүүдээр хичээл төлөвлөх гэсэн агуулгаар ойлголт өглөө.



Мөн сумын хэмжээнд зохион байгуулагдаж буй төрийн албан хаагчдын сарын аяны хүрээнд багш нараар сумын хэмжээнд албан байгууллагуудад сургалт зохион байгуулах, нөлөөллийн ажлын удирдамж боловсруулан танилцуулж, заавар зөвлөгөө өглөө.

Түүнчлэн анги удирдсан багш нар хүүхдээр дамжуулан эцэг эх, гэр бүлдээ нөлөөлөх, эрчим хүчээ сургууль болон гэртээ хэрхэн зөв зохистой хэрэглэж болох талаар сургалтаас гадна олон талын ажлуудыг зохион байгуулах талаар ярилцлаа.

Уг мэдээлэлд хамрагдсан байгууллагуудын оролцоог харуулбал:

1. Сургууль- 22 багш, 25 ажилчдад - Р.Дагийсүрэн,
2. Сумын ЗДТГ, соёлын төв - 15 хүнд Б.Саранчимэг, П.Нандинцэцэг
3. СДЭ - 14 хүнд
4. СӨБ - Г.Үүрийнтуяа Б.Уранмандах- ар гэрийн шалтгаанаар ирэх 7 хоногт нөхөхөөр хойшлуулсан
5. “Ялалт” музей – 6 хүн
6. ЗХ- 329-р анги – 14 хүнд
7. ХЦ -0198-р анги - 40 хүнд
8. Дархан газар, цаг уур- 5 хүнд
9. ОБГ- аврах 162-р анги - 13 хүн
10. Банкууд – 6 хүн
11. Ахмадын хороо – 9 хүнд
12. Бизнесийн холбоо – 15 хүнд \ ААН, дэлгүүрийн\ Нийт 12 байгууллагын 199 хүнд хүрч ажилласан байна.

ТАЙЛАНГ НЭГТГЭСЭН: БОЛОВСРОЛ, СОЁЛ, УРЛАГИЙН ГАЗРЫН
МЭРГЭЖИЛТЭН Ж.БУМТУЯА

Эрчим хүчний хэмнэлт, зохистой хэрэглээ хичээлийн тайлан

Дорнод аймаг

Чулуунхороот сумын сургууль: Бага ангийн 181 сурагчдад “Эрчим хүчний хэмнэлт зохистой хэрэглээ” сургалтаар цахим хичээлүүдийг ашиглан зохион байгуулав. Эцэг эхчүүдийн сэтгэл ханамж өндөр байлаа. Эрчим хүчний хэрэглээний талаар 5 асуулт бүхий судалгаа 2-5 дугаар ангийн сурагчдаас авч дүнг нэгтгэв.

1. Танайх гэрлээ унтраадаг уу. Унтраадаг-79%
2. Залгуураа салгадаг уу? Салгадаг-38%
3. Өдрийн гэрэл хэрэглэдэг үү? Өдрийн гэрэл хэрэглэдэг-76%
4. Телевизороо яаж унтраадаг вэ? Удирдлагаар нь унтраадаг-60%
5. Гэрээсээ гарахдаа цахилгаан хэрэгсэлээ салгаж гардаг уу? Салгадаг-70%

Судалгаанаас харахад ихэнх айл цахилгаан эрчим хүчээ хэмнэх талаар бага мэдлэгтэй байна.


Анги тус бүр хөтөлбөрийн дагуу 9 цагийн сургалтыг явуулав. Хүүхдэд энэ төрлийн мэдлэг бага байсан нь сургалтын явцад харагдаж байсан. Танин мэдэхүйн түвшинд 4-5 ангийн сурагчид идэвхтэй оролцож, эрчим хүчээ хэмнэх талаар дадал хэвшилд суралцлаа. Сургалтын үр дүнг 5 асуултаар дүгнэв.

1. Танай гэрийнхэн цахилгаанаа хэмнэдэг үү? Хэмнэдэг-96%
2. Чи орой гэрлээ унтраадаг уу? Унтраадаг-95%
3. Танай гэрийнхэн утсаа цэнэглэж дуусаад цэнэглэгчээ салгадаг уу? Салгадаг-100%
4. Танайх гэртээ ямар гэрэл хэрэглэдэг вэ? Өдрийн гэрэл, лед хэрэглэдэг-80%
5. Ангийнхаа гэрлийг тогтмол унтрааж сурсан уу? Тогтмол унтраадаг-100%

Эрчим хүчээ хэмнэх талаар дараах зөвлөмжийг сурагчдаар гаргуулав.

- Чи гэрэл цахилгаанаа хэмхэн талаар найздаа зааж өгөөрэй.
- Чи гэрийнхэндээ гэрлээ унтраа гэж тогтмол хэлж сурсан уу?
- Явал цахилгаан хэмнэх талаар сайн бодоорой.

ЭРЧИМ ХҮЧЭЭ ХЭМНЭЖ ЭХ ДЭЛХИЙГЭЭ ХАЙРЛААРАЙ!



<http://erc.gov.mn>

<http://ecc.erc.gov.mn>

Эрчим хүч зохистой хэрэглээ



Эрчим хүчний
үнэ цэнэ



Д.Наранцэцэг

Эрчим хүчний зохицуулах хороо

Эрчим хүч хэмнэлтийн газар

Судалгаа, арга зүй хариуцсан мэргэжилтэн

narantsetseg.d@erc.gov.mn

Утас: 319317

99126465